

**БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО БА ҮНДЭСНИЙ ӨВ, СОЁЛЫГ СУРГАЛТЫН
АГУУЛГА, ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН БАЙДЛЫН ТАЛААРХ
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Д.Халиун, Б.Нандингэрэл
И.Жаргалзаяабямба*

АГУУЛГА

УДИРТГАЛ

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО БОЛОН ҮНДЭСНИЙ ӨВ, СОЁЛЫГ СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН БАЙДЛЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

- БНСУ
- СИНГАПУР
- ЯПОН
- ФИНЛАНД
- НОРВЕГ
- КАНАД
- ХБНГУ
- ЭСТОНИ
- ШИНЭ ЗЕЛАНД
- НИДЕРЛАНД

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны хамрах хүрээ: Энэхүү судалгаагаар Олон улсын боловсролын үнэлгээний хөтөлбөр (PISA)²⁷⁸-ийн чанарын үнэлгээний эрэмбэд тогтмол дээгүүр байр эзэлдэг БНСУ, Канад, Нидерланд, Норвег, Сингапур, Финланд, ХБНГУ, Шинэ Зеланд, Эстони, Япон зэрэг улсын ерөнхий боловсролын тогтолцооны талаар судалсан болно. Судалгааны сэдвийн хүрээнд дээрх орнуудын ерөнхий боловсролын тогтолцоо (сургуульд хүүхдийг хэдэн наснаас хамруулдаг, гадаад хэлийг хэдэн наснаас зааж эхэлдэг, ерөнхий боловсролын сургалтын агуулга буюу сургалтын хөтөлбөр, сурах бичигт үндэсний өв, соёлыг ямар хувь хэмжээтэй тусгадаг гэх мэт)-ны асуудлуудыг холбогдох хууль эрх зүйн орчны хүрээнд судаллаа. Судалгааны дүнг Хүснэгт 2-т хураангуйлан үзүүлэв.

Судалгааны үр дүнгийн тойм: НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО)-ын тоо мэдээнээс үзэхэд дэлхийн 218 улсаас хүүхдийг 6 наснаас нь эхлэн сургуульд хамруулдаг - 151 улс, 5 наснаас эхлэн хамруулдаг - 31 улс, 7 наснаас эхлэн хамруулдаг - 36 улс байна.

Хүснэгт 1. Дэлхийн улс орнууд сургуульд хүүхдүүдийг хэдэн наснаас хамруулдаг

№	Бага сургуульд хамрагдах эхлэх нас	Улсын тоо, хувь	Улсын нэр
1	5 нас	31 улс - 14 хувь	Австрали, Ирланд, Мальт, Мьянмар, Непал, Шинэ Зеланд, Пакистан, Их Британи зэрэг
2	6 нас	151 улс - 69 хувь	АНУ, Австри, Бельги, Канад, Хятад, Хонконг, Макао, Кипр, Чех, Дани, Франц, Гүрж, ХБНГУ, Грек, Исланд, Израил, Итали, Япон, Люксембург, Малайз, Нидерланд, Норвег, БНСУ, Сингапур, Словак, Словени, Турк, Украйн зэрэг
3	7 нас	36 улс - 17 хувь	Афганистан, Болгар, Хорват, БНАСАУ, Эстони, Финланд, Унгар, Индонез, Казахстан, Кыргыз, Латви, Лихтенштейн, Литва, Польш, Молдов, ОХУ, Серб, Өмнөд Африк, Швед, Швейцар, Узбекистан зэрэг

Эх сурвалж: НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага, 2016²⁷⁹

Ерөнхий боловсролын тогтолцоо

Дэлхийн улс орнуудын ерөнхий боловсролын тогтолцоонд сүүлийн 15-20 жилийн хугацаанд хэд хэдэн үзүүлэлтээр “ижилсэх” хандлага ажиглагдаж ирсэн. Эдгээр үзүүлэлтийн тоонд: ерөнхий боловсролын сургалтын үргэлжлэх хугацаа (12 жилийн сургалттай тогтолцоо давамгайл), дунд боловсролын төгсөх ангиудад мэргэжлийн чиг баримжаа олгох, төгсөлтийн ерөнхий шалгалтын үндсэн дээр аттестатжуулах зэрэг байна.

Дэлхийн улс орнуудын хувьд дийлэнх буюу 80%-д нь ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоотой байна. ОХУ болон зарим Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орон (СНГ), Латин Америкийн зарим улс 11 жилийн тогтолцоотой байгаа бол франц, англи загварын тогтолцоо бүхий Ази, Африкийн орнууд голчлон 12 жилийн тогтолцоотой байна. Хамгийн түгээмэл хэлбэр нь бага боловсрол 4-6 жил, дунд болон ахлах сургуулиуд нь 3-5, 2-4 жил байна. Ийнхүү ерөнхий боловсролын дараах загварууд түгээмэл байна. Үүнд:

$$6+3+3=12 \text{ (хамгийн түгээмэл)}$$

$$5+4+3=12$$

$$6+5+2=13$$

Финланд, Дани, Швед болон АНУ-ын зарим муж улсад бага боловсрол гэж тухайлан заадаггүй ба сургуулийн анхан шатны 8-9 жилийн тогтолцоог суурь боловсрол гэж тооцдог байна.

²⁷⁸ <https://www.theguardian.com/education/2014/may/06/oecd-pisa-tests-damaging-education-academics>

²⁷⁹ <http://data.uis.unesco.org>

Мэргэжлийн чиг баримжаа олгох. Хөгжингүй болон шилжилтийн эдийн засаг бүхий орнуудын дийлэнхэд сургуулийн ахлах ангиудын 2-4 жил (гол төлөв 3 жил)-ийн хугацаанд тодорхой чиглэлээр дагнан суралцах нь түгээмэл байх ба үүнийг боловсролын гэрчилгээнд тодорхой байдлаар тэмдэглэдэг байна. Их, дээд сургуульд элсэн суралцахад тодорхой чиглэлээр суралцаж төгссөн сурагчид давуу эрх эдлэх ба тухайн их, дээд боловсролын байгууллагын чиглэл нь сурагчийн сонгон суралцсан чиглэлээс зөрөх тохиолдолд нэмэлт шалгалт авах, эсхүл элсүүлдэггүй байна. Энэхүү тогтолцооны сонгодог жишээ нь Францын боловсролын тогтолцоо юм. Гурван жилийн лицейн сургалт нь тодорхой чиглэлүүдэд хуваагдах ба сурагчид сургуулиа төгсөхдөө тодорхой чиглэлээр суралцсан төгссөнийг гэрчлэх тэмдэглэгээ бүхий гэрчилгээ авна. Францын ерөнхий боловсролын сургуулийн гэрчилгээ, сургалтын чиглэл нь одоогийн байдлаар 7 салбарт хуваагдах ба үүнээс 3 салбар нь академик сургалт, 4 салбар нь мэргэжлийн чиглэлээр олгогддог байна. Бельги, ХБНГУ, Испани, Португал, Швед, АНУ-ын зарим муж, Ази, Африк, Латин Америкийн цөөнгүй орнуудад дээрхтэй ерөнхий боловсролын ахлах боловсролын тогтолцоотой байна.

Гадаадын улс орнуудад ерөнхий боловсролын төгсөх ангид мэргэжил олгоход чиглэсэн сургалтыг 3 хувааж үздэг. Нэгдүгээрт, тодорхой хичээл, бүлэг хичээлээр сургалт явуулдаг ИБУИНВУ, АНУ-ын зарим муж улс, Канад болон Азийн зарим улс ордог. Хоёрдугаарт, хамгийн түгээмэл дэлгэрсэн загвар буюу нийгэм, байгалийн ухаан, хүмүүнлэгийн ухаан, эдийн засаг, технологийн зэргээр хуваарилдаг Франц, Бельги, БНСУ болон бусад орнууд. Гуравдугаар загварт, ирээдүйд эзэмших мэргэжлийн чиглэлээр сургалт явуулдаг ХБНГУ (хэсэгчлэн), Швед зэрэг орж байна. Практикт мэргэжил олгоход чиглэсэн сургалтын холимог тогтолцоо түгээмэл дэлгэрсэн байдаг ба энэ нь 2-3 үндсэн чиглэлийн хүрээнд сургалт явагдсаны дараагаар илүү мэргэшүүлсэн чиглэлд шилжих загвар юм.

Олон үндэстний соёлын сургалт. Үндэсний болон дэлхийн өв соёлын мэдлэг, үндэс суурийг тавих нь улс орон бүрийн сургуулийн боловсролын гол зорилтын нэг байдаг. Үүнийг түүх, уран зохион, философи, урлаг, дуу хөгжим зэрэг бага, дунд боловсролын хичээлийн агуулгад тусгах замаар хэрэгжүүлдэг. Өнөө цагт дэлхий дахинаа үндэсний өв соёлд чухал ач холбогдол өгөхөөс гадна “cross-culture” буюу олон соёлын боловсрол эзэмшүүлэхэд чиглэгдэж байгаа нь дэлхий дахинаа нийгэм, эдийн засгийн даяаршил эрчимтэй явагдаж байгаатай холбоотой. Үүнийг улс орнуудын ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөөнд гадаад хэлний мэдлэг, сургалтад тавигдаж буй шаардлагаас харж болох юм. Тухайлбал, Европын Холбооны гишүүн орнуудад дунд боловсролын хүрээнд хоёр гадаад хэл сурах шаардлага тогтоон, гурав дахь гадаад хэл судлахыг хөхүүлэн дэмждэг. Түүнчлэн, дунд боловсролын төгсөх ангиудад, нэн ялангуяа хүмүүнлэгийн чиглэлээр суралцаж буй сурагчдад “дэлхийн шашин”, “дэлхийн соёл иргэншлүүд”, “соёл хоорондын харьцаа” зэрэг соёл иргэншлийн олон янз байдал, тэвчих үзэлд суурилсан хичээлүүд ордог байна. Дээрхтэй ижил, төстэй хичээлүүд АНУ, Япон, БНСУ, Сингапур зэрэг улсын ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрийн агуулгад туссан байна. Европын Холбооны Болонийн процесст хамрагдсан улс орнуудын ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө болон хичээлийн агуулгад европ өв соёлыг хадгалахад чиглэсэн, “европ хэв загвар/хэв шинж” оруулах үйл ажиллагаа хийгдэж ирсэн байна.

Хичээлийн ачаалал, гэрийн даалгавар. Сүүлийн жилүүдэд хөгжингүй улс орнуудад бага боловсролын хүрээнд хийгдэж буй шинэтгэлүүд нь хичээлийн ачааллыг бууруулах, хичээлийг илүү сонирхолтой, тоглоом, наадгай байдлаар явуулах, бие бялдрыг хөгжүүлэхэд чиглэсэн хичээлийн тоог нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна. Дунд, болон ахлах сургуулийн хүрээнд мөн хичээлийн ачааллыг бууруулж, бие даан судлах, сонголтоор судлах хичээлийн цагийг нэмэгдүүлж байна. Ихэнх улс орны хувьд гэрийн даалгавартай холбоотой асуудлыг харьцангуй ижил төстэй байдлаар зохион байгуулсан ба бага сургуульд гэрийн даалгавар төдийлөн өгдөггүй (Бельги, Франц Улсад хориглосон) бол дунд болон ахлах ангиудад гэрийн даалгаврын уламжлалт бүх хэлбэрүүд түгээмэл дэлгэрсэн байна.

Гадаад хэлний сургалт

Бага боловсролын хүрээнд хүүхдэд гадаад хэлийг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зааж

эхлэх насны хувьд:

- БНСУ-д бага сургуулийн 3 дугаар ангиас;
- Сингапурт бага сургуулийн 1 дүгээр ангиас англи болон эх хэл (малай, мандарин, тамил);
- Японд гадаад хэлийг 7-р ангиас; (гадаад хэл зааж эхлэхээс өмнө япон хэл, соёлыг бүрэн танин мэдсэний дараа гадаад хэл заах нь үр дүнтэй гэсэн бодлогыг баримталдаг байна).

Харин Европын орнуудын хувьд ерөнхий боловсролын сургууль дахь гадаад хэлний сургалт дараах байдалтай байна.

1995 оны Европын холбооны Цагаан баримт бичигт “суурь сургалтыг дүүргэснээр хүн бүр Холбооны 2 гадаад хэлийг эзэмшсэн байна” гэж заасан, 2000 оны Лисабоны Саммитээр гадаад хэлний мэдлэгийг 5 үндсэн чадварын тоонд оруулсан байна. 1990-ээд оноос олон улсын гадаад хэлний **“Common European Framework of Reference for Languages”** стандартыг нэвтрүүлж, гадаад хэлний сургалтыг ижилсүүлэх, уялдуулах ажлууд хийгдэж ирсэн байна.

1974 онд Европын холбооны гишүүн орнуудаас Ирланд, Их Британиас бусад бүх оронд заавал судлах хичээлийн тоонд нэг гадаад хэл орж байсан бол 1998 онд Ирландаас (Ирланд болон Ангил хэл дээр хичээл явагдах боловч, аль нь ч гадаад хэлд тооцдоггүй, түүнчлэн гурав дахь гадаад хэлийг заадаг) бусад бүх оронд гадаад хэлний сургалт суурь боловсролын тогтолцоонд багтсан. Бельги, Франц, Дани, Нидерланд, Герман, Люксембург, Финланд, Швед, Исланд, Швейцар, Грек, Хорват, Кипр, Эстони, Латви, Литва, Польш, Румын, Серб, Словени болон Словак зэрэг улсын ахлах дунд боловсролын сургуулиудын сурагчид доод тал нь хоёр гадаад хэл судалдаг байна.

Европын хэмжээнд гадаад хэлний анхан шатны хичээл долоо хоногт 3-4 цагаар ордог ба бага сургуулийн төгсөлд, эсхүл дунд сургуулийн эхэнд гадаад хэл дээрх хичээлүүдийг зааж эхэлдэг байна. Люксембург, Норвег, Итали, Мальт зэрэг улсад нэгдүгээр гадаад хэлийг 6 наснаас, Шведэд 7 наснаас, Бельгид 10 наснаас тус тус зааж эхэлдэг байна. Европын Холбооны бага сургуулиудын тал хувьд нь гадаад хэлний сургалт явуулдаг байна.

Дунд сургуульд хамгийн түгээмэл заадаг гадаад хэл нь англи хэл байх ба Европын Холбооны гишүүн орнуудын сурагчдын 93 хувь нь англи хэл судалдаг байна. Ахлах дунд сургуулиудад англи хэлний хэрэглээ, сургалт илүү өргөн хүрээтэй явагддаг. Словениас бусад бүх Европын Холбооны гишүүн оронд франц хэлийг дунд сургуульд үздэг ба Европын Холбооны орнуудын дунд сургуулийн сурагчдын 33 хувь нь франц хэл судалдаг бол ахлах дунд сургууль тус үзүүлэлт 28 хувьтай байна. Герман хэлийг Европын Холбооны гишүүн улсын дийлэнхэд судалдаг ба дунд сургуулийн сурагчдын 13%, ахлах дунд сургуулийн 20% нь герман хэлийг судалдаг байна.

Үндэсний өв, соёлыг сургалтын хөтөлбөр, агуулгад тусгасан байдал

Судалгаанд хамрагдсан 10 улсын хувьд ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөр, агуулгад үндэсний өв соёлыг хэрхэн тусгасныг авч үзвэл эх хэл, уран зохиол, түүх, газар зүй, нийгмийн ухаан, дуу хөгжим зэрэг хичээлүүдээс гадна ёс зүй/ёс суртахууны хичээл (БНСУ, Япон), иргэний боловсролын хичээл (Сингапур), библи судлал (Норвег) зэрэг хичээлийн хөтөлбөрт туссан байна.

Иргэний боловсролын хичээл. Ерөнхий боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг судалгааны тайланд “Иргэний боловсрол”²⁸⁰-ыг дараах байдлаар тайлбарласан байна. Иргэний боловсрол хэмээх ойлголт нь Civic education, Citizenship education хэмээх хоёр ойлголтоор илэрхийлэгддэг бөгөөд боловсролын харилцаанд янз бүрийн утгаар хэрэглэгдэж байна. Зарим судлаач "civic education" буюу иргэний боловсрол нь хүүхэд, залуучуудыг нийгмийн идэвхтэй гишүүн болгон бэлтгэх боловсролын салбар, харин "citizenship" буюу иргэншил нь тухайн

²⁸⁰ Иргэний боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг, Судалгааны тайлан, ННФ. УБ., 2011. 68-70 дахь тал

нийгмийн гишүүд иргэн болон төлөвших үйл явцыг тэмдэглэсэн ойлголт хэмээн ялган үздэг байна.

НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО)-аас 1987 онд "Хүний эрхийн сургалт, мэдээлэл ба баримт бичиг" сэдвээр Мальт Улсад зохион байгуулсан олон улсын бага хурлаас НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хандан "бүх иргэн, хүн амын бүлэгт хүртэх боломжтой хүний эрхийн боловсрол, сургалтын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатайг гишүүн улс орнуудын анхааралд хүргэн", "түүх, иргэний боловсрол зэргийн хөтөлбөрт хүний эрхийн агуулгыг тусгаж, зөрчлийг энхийн замаар шийдвэрлэх, хүчирхийллийн бус стратегийг боловсруулах, улмаар гишүүн орон бүрийн тухайн боловсролын талаарх амжилт ололтыг 5 жил тутамд үнэлж байх" талаар зөвлөжээ.

1999 онд хэрэгжүүлсэн Иргэний боловсролын олон улсын харьцуулсан судалгаанд хамрагдсан улс орнууд Иргэний боловсролтой холбогдох зорилго, зорилтуудыг янз бүрээр тодорхойлдог болохыг онцолжээ. Тэдгээрийг тоймлон үзвэл дараах хэдэн зорилт илүү нийтлэг байна:

- Хувь хүний чадавх, бололцоог нэмэгдүүлэх;
- Тэгш бололцоог дэмжих;
- Залуу үеийг ажил хөдөлмөрт бэлтгэх;
- Цаашдын буюу дээд боловсрол эзэмших үндэс суурийг тавих;
- Мэдлэг, чадвар, ойлголт бий болгох;
- Иргэншил буюу ардчилал ба нийтлэг хэм хэмжээнд суралцуулах;
- Соёлын өв уламжлалаа хадгалах, эдлэх явдал зэрэг болно.

Үүнээс үзэхэд иргэний боловсрол нь хүний эрх, ардчилал, улс төр, иргэн - төрийн харилцаа, шийдвэр гаргах үйл явцын талаар мэдлэг эзэмших, чадвар, хандлагаа хөгжүүлэх үйл явцыг багтаасан, олон бүрэлдэхүүн хэсэг бүхий насан туршийн боловсрол юм. Иргэний боловсролын агуулгад мөн плюрализм, олон соёлт орчин, угсаатны ба соёлын өв уламжлал, нийгмийн ялгарал, хүлээцтэй хандах байдал, нийгмийн зүй ёс, үндэсний онцлог, ухаалаг байдал, байгаль орчны ач холбогдлын мэдрэмж зэрэг олон шинэлэг асуудал тусдаг байна.

Баримт бичгүүд болон судлаачдын үзэл бодлоос харахад иргэний боловсролын гол зорилго нь суралцагч, өсвөр үе, залуучууд өөрсдийн эрх, эрх чөлөөгөө мэдэж, шийдвэр гаргах үйл явцад оролцох, байр сууриа илэрхийлэх чадвараа хөгжүүлэхэд туслах, оролцоо бүхий нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх, чиг баримжаа олгоход чиглэж байна. Хүн нийгмийн амьдралын олон талт харилцаанд оролцдог учир тухайн хүнд нийгмийн харилцааны үндэс суурь, зарчмууд, үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдлэг, ойлголт байх шаардлагатай. Тиймээс иргэний боловсролын хичээлийн агуулга нь улс төр, эдийн засаг, нийгэм, ёс суртахуун, соёлын гэсэн 5 үндсэн ай (домайн)-н хүрээнд боловсрогдож, эдгээрийн талаар зохих мэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэх нь зүйтэй хэмээн судлаачид үздэг байна.

Дэлхийн улс орнуудад "Иргэний боловсрол"-ын агуулгыг олон хичээлийн хүрээнд багтаан олгодог. Тухайлбал, нийгмийн ухаан, нийгэм судлал, дэлхий судлал, хүн ба нийгэм, амьдралын ухаан, албан ахихуй, хүний эрхийн боловсрол, ёс зүйн боловсрол, эрх зүйн боловсрол зэрэг олон хичээлийн хүрээнд улс орнууд өөрийн иргэддээ орчин үеийн нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, ёс суртахууны харилцааны үндсийг заан сургаж, тэдгээр харилцаанд үр ашигтай оролцох талаар зохих чадвар, хандлагыг төлөвшүүлж иржээ. Түүнээс гадна иргэний боловсрол нь түүх, газар зүй, эдийн засаг, улс төр судлал, байгаль орчин судлал, шашин судлал, төрөлх ба гадаад хэл зэрэг бусад хичээлүүдтэй харилцан холбогдож, иргэдийг нийгмийн харилцаанд бэлтгэхэд чиглэдэг байна.

Хүснэгт 2. Гадаадын зарим улсын ерөнхий боловсролын тогтолцоо

№	Улсын нэр	Бага суругульд хамрагдах нас	Ерөнхий боловсролын тогтолцоо (жилээр)			Гадаад хэлийг зааж эхлэх нас, анги	ЕБС-н сургалтын хөтөлбөрт үндэсний өв, соёлын талаар тусгасан байдал
			Бага сургууль	Дунд сургууль	Ахлах сургууль		
1	ХБНГУ	6 нас	4 жил	6 жил	4 жил	9 нас	Газар зүй, улс төрийн шинжлэх ухаан, түүх, эх хэл, дуу хөгжим, шашин
2	Канад ²⁸¹ (Онтарио)	6 нас	6 жил*	4 жил*	1-4 жил	-	
3	Нидерланд	5 нас	8 жил	4-6 жил	1-4 жил	7-р анги	
4	Норвег	6 нас	4 жил*	3 жил*	3 жил*	1-р анги	Эх хэл, библи судлал
5	БНСУ	6 нас	6 жил*	3 жил*	3 жил	3-р анги	Эх хэл, түүх, ёс зүйн хичээл
6	Сингапур	6 нас	6 жил*	4-5 жил*	2-3 жил	1-р анги	Иргэний боловсролын хичээл
7	Финланд	7 нас	9 жил		3 жил	3-р анги	
8	Шинэ Зеланд	5 нас	8 жил*	2 жил*	3 жил	1-р анги	
9	Эстони	7 нас	4 жил*	5 жил*	3 жил	1-р анги	
10	Япон	6 нас	6 жил*	3 жил*	3 жил	7-р анги	Ёс зүйн хичээл

Тайлбар: *суурь боловсрол

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО БОЛОН ҮНДЭСНИЙ ӨВ, СОЁЛЫГ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН БАЙДЛЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

1.БНСУ

БНСУ-д боловсролын салбарын хууль эрх зүйн орчинг Үндсэн хууль, Боловсролын суурь хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Насан туршийн боловсролын тухай хууль, Боловсон хүчний хөгжлийн суурь хууль зэрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд бүрдүүлж байна.

БНСУ-ын Үндсэн хуульд боловсролтой холбоотой асуудлыг дараах байдлаар тоймлосон байна. (31 дүгээр зүйл):

1. Иргэн бүр тэгш эрхтэйгээр сурч боловсрох эрхтэй байна;
2. Иргэн бүр хүүхэд дээ бага сургуулийн болон хуульд заасан бусад боловсролыг олгох үүрэгтэй;
3. Суурь боловсролыг үнэ төлбөргүй олгоно;
4. Боловсролын байнгын, мэргэшсэн, төвийг сахисан байдлыг хуулиар тогтооно;
5. Төр насан туршийн боловсролыг хөхүүлэн дэмжинэ;
6. Сургууль болон насан туршийн боловсрол, удирдлага, санхүүжилт, багш нарын эрх зүйн байдал зэрэг боловсролын тогтолцоонд хамаарах суурь асуудлуудыг хуулиар тогтооно” гэж заасан.

Суурь боловсрол

1997 онд батлагдсан Боловсролын суурь хууль (*Framework Act on Education*)-ийг²⁸² баталсан бөгөөд уг хуулиар иргэдийн эрх, үүрэг, Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны үүрэг, боловсролын тогтолцоо болон үйл ажиллагааны суурийг тогтоож өгсөн

²⁸¹ Муж бүрээр ялгаатай

²⁸² http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=42697&type=part&key=16

байна. Хуулийн 8 дугаар зүйлд Суурь (заавал эзэмших) боловсрол²⁸³ нь **бага боловсрол 6 жил, дунд боловсрол 3 жил** байна. Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу суурь боловсролыг үнэ төлбөргүй олгоно.

1997 онд батлагдсан Бага, дунд боловсролын тухай хууль (*Elementary and Secondary Education Act*)-ийн 46 дугаар зүйлд заасны дагуу **ахлах сургууль 3 жил** байна. Харин 49 дүгээр зүйлд заасан цагийн сургалт болон зайны сургалт²⁸⁴ нь 4 жил байна.

Сургуульд хамрагдах нас

Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу иргэн бүр хүү/охиноо, эсхүл өөрийн асрамжид байгаа хүүхдийг **6 нас хүрч буй** тохиолдолд 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн бага боловсрол эзэмшиж дуустал нь бага сургуульд хамруулах үүрэг хүлээнэ. 1 дэх хэсэгт заасныг үл харгалзан иргэн нь хүү/охин, эсхүл өөрийн асрамжид байгаа хүүхдийг 5, эсхүл 7 нас хүрэхэд нь бага сургууль оруулж болно. Иргэн бүр өөрийн хүү/охиноо, эсхүл өөрийн асрамжид байгаа хүүхдийг бага сургуулиа төгссөний дараах жил дунд сургууль явуулж, дунд боловсрол эзэмшиж дуустал нь дунд сургуульд хамруулах үүрэг хүлээнэ.

Мөн хуулийн 68-р зүйлд заасны дагуу иргэн нь өөрийн хүү/охин, эсхүл өөрийн асрамжид байгаа хүүхдээ дунд сургуульд хамруулаагүй бол 1 сая хүртэлх воны торгууль ногдуулна.

Гадаад хэлний сургалт

1997 оноос англи хэлийг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт оруулж, бага сургуулийн хувьд **бага ангийн 3 дугаар ангиас эхлэн** 3-4 дүгээр ангид долоо хоногт 1 цаг, 5-6 дугаар ангид 2 цаг тус тус заадаг болсон.

Боловсролын агуулга

Бага сургуулийн сургалтын хөтөлбөрт үндсэн хичээлүүд болох ёс зүй/ёс суртахуун²⁸⁵, эх хэл, гадаад хэл, математик, шинжлэх ухаан, нийгмийн ухаан, биеийн тамир, дуу хөгжим болон урлагийн хичээлүүд ордог байна. Жилд 34 гаруй долоо хоногийн хичээл орох бөгөөд, бага ангийн 1-2 дугаар ангид 850 цаг, 3-4 дүгээр ангид 986 цаг, 5-6 дугаар ангид 1088 цагийн хичээл тус тус үздэг байна.

Дунд сургуульд математик, эх хэл, англи хэл, нийгмийн ухаан болон шинжлэх ухааны чиглэлээр гүнзгийрүүлэн, ёс зүй/ёс суртахуун, биеийн тамир, дуу хөгжим, урлаг болон дүрслэх урлаг зэрэг бусад үндсэн хичээлүүд орно. Дээрх үндсэн хичээлүүдээс гадна сурагчид нэмэлт болон сонгон суралцах хичээлүүд болох хөдөлмөр (гэр ахуй), технологи, гадаад хэл, мэдээлэл зүйн болон технологи болон байгаль орчин (хүрээлэн буй орчин) зэрэг хичээлүүд ордог байна.

Бага, дунд боловсролын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу ахлах сургуульд дунд сургуульд суралцаж төгссөн, шаардлагатай шалгалтуудыг өгч тэнцсэн сурагч ахлах сургуульд суралцах эрхтэй байна. Ахлах сургуулиуд нь энгийн/ерөнхий, тусгай/гүнзгийрүүлсэн (гадаад хэл, урлаг, шинжлэх ухааны гүнзгийрүүлсэн сургалттай), мэргэжлийн ахлах сургууль, бие даасан ахлах сургууль²⁸⁶ гэсэн 4 төрөлтэй байна.²⁸⁷

Улсын болон хувийн сургуулиуд нь Боловсролын яамнаас боловсруулж, баталсан үндэсний сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт явуулах бөгөөд ахлах сургуулийн 1 дүгээр анги (10-р анги)-д үндсэн 10, өөрийн сонирхсон 10 хичээл сонгон суралцах бөгөөд үндсэн хичээлд: эх хэл, ёс зүй, нийгмийн ухаан (түүх), математик, шинжлэх ухаан, хөдөлмөр болон гэр ахуй, биеийн тамир, дуу хөгжим, дүрслэх урлаг болон англи хэлний хичээлүүд ордог байна.

Ахлах сургуулийн 1 дүгээр ангиа (10-р анги) дүүргэсний дараа сурагчид хүмүүнлэг,

²⁸³ compulsory education

²⁸⁴ part-time and correspondence systems

²⁸⁵ ethics/moral education

²⁸⁶ autonomous high school

²⁸⁷ Ministry of Education, Korea <http://english.moe.go.kr/sub/info.do?m=020103&s=english>

нийгмийн ухаан (газар зүй, түүх, улс төр, эдийн засаг, соёл), байгалийн ухаан (физик, хими, биологи, дэлхий судлал/гео судлал) гэх дөрвөн чиглэлээс, эсхүл мэргэжлийн сургалтыг сонгон гүнзгийрүүлэн суралцах юм. Ахлах сургуульд суралцаж төгссөн сурагчдад Бүрэн дунд боловсролын гэрчилгээ олгоно.

Мэргэжлийн ахлах сургуулиуд /техникийн сургууль нь эхний жилдээ ерөнхий дунд боловсрол олгох бөгөөд хөдөө аж ахуй, аж үйлдвэр, худалдаа, загасны аж ахуй/далайн, хөдөлмөр, гэр ахуй²⁸⁸ зэрэг чиглэлээрх тусгай хичээлүүд 2-3 дугаар анги (11-12-р анги)-д ордог байна. Дээрх сургуульд суралцаж төгссөнөөр сурагчдад Мэргэжлийн дунд боловсролын гэрчилгээ олгоно.

Бие даасан ахлах сургууль нь бусад сургуультай харьцуулахад олон талт, тусгай/онцгой сургалтын хөтөлбөрийг харьцангуй бие даасан байдлаар хэрэгжүүлэх боломжтой байдаг. Бие даасан ахлах сургуулиуд улсын болон хувийн сургууль байж болно.

Бага, дунд боловсролын тухай хуульд заасны дагуу Боловсролын яамнаас боловсруулж, баталсан сургалтын агуулга, стандартын дагуу бүх суралцагчид ижил, тэнцүү боломжоор хангагдаж, эрх тэгш ерөнхий боловсрол эзэмшинэ.

Сургалтын хөтөлбөрийг нийгэмд гарч буй өөрчлөлтүүдтэй уялдан гарч буй хэрэгцээ, шаардлага, шинээр гарч ирж буй мэдлэгийн салбар зэрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулах бөгөөд БНСУ-ын хувьд сургалтын хөтөлбөрөө нийт 7 удаа шинэчилсэн байна. 7 дугаар буюу хамгийн сүүлийн шинэчлэлийг 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталсан бөгөөд бага, дунд сургуульд 2000 оноос нэвтрүүлж эхэлсэн байна. Тус хөтөлбөрийг даяаршил болон мэдээлэлд суурилсан нийгмийн шаардлагад нийцүүлэхийг зорьсон ба уламжлалт сургалтын арга барил буюу мэдлэг, мэдээллийг “халбагадаж” олгодгоос бие даан суралцах, сурагч тус бүрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон хэлбэрийг нэвтрүүлэх, өргөжүүлэх, хичээлийн ачааллыг бууруулах тал дээр анхаарсан байна.

Шинэ хөтөлбөрийн хүрээнд бага сургуулийн 1 дүгээр ангиас ахлах сургуулийн 1 дүгээр анги (1-10-р анги)-н үндсэн хөтөлбөрөөр хичээллэх бол ахлах сургуулийн 2-3 дугаар анги (11-12-р анги)-д сурагчид өөрсдийн ирээдүйн зорилго, зорилтод нийцүүлэн сурах хичээлүүдээ сонгон суралцах юм.

Хүснэгт 3. Бага, дунд, ахлах сургуулийн хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн тойм

Хөтөлбөрийн шинэчлэл явагдсан тойм	Огноо	Хөтөлбөр	Онцлог
1 дүгээр шинэчлэл	1954.04.20 1955.08.01	Ordinance on class time assignment Бага сургуулийн хөтөлбөр Дунд сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр	Сургуулийн боловсрол дээр төвлөрсөн сургалтын хөтөлбөр
2 дугаар шинэчлэл	1963.02.15	Бага сургуулийн хөтөлбөр Дунд сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр	- Туршилтын сургалтын хөтөлбөр - Ханз - Цэргийн дасгал
3 дугаар шинэчлэл	1973.02.14 1973.08.31 1974.12.31	Бага сургуулийн хөтөлбөр Дунд сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр	- Академик сургалтыг баяжуулах, өргөжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр - Ёс зүй - Түүх - Япон хэл
4 дүгээр	1981.12.31	Бага сургуулийн	- Сурах хичээлийн хэмжээг

²⁸⁸ home economics

шинэчлэл		хөтөлбөр Дунд сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр	бууруулах/зохицуулах - Бага сургуулийн 1-2 ангийн хөтөлбөрийн нэгтгэсэн удирдлага
5 дугаар шинэчлэл	1987.03.31 1987.07.31 1988.03.31	Бага сургуулийн хөтөлбөр Дунд сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр	- Шинжлэн ухааны ахлах сургууль, Дүрслэх урлагийн ахлах сургууль - Бага сургуулийн нэгтгэсэн сургалтын хөтөлбөр - Шинэ хичээл: Мэдээллийн салбар - Эдийн засгийн боловсролд чиглэсэн - Бүс нутгийн шинж чанарт ач холбогдол өгсөн
6 дугаар шинэчлэл	1992.06.31 1992.09.31 1992.10.31 1995.11.01	Дунд сургуулийн хөтөлбөр Бага сургуулийн хөтөлбөр Ахлах сургуулийн хөтөлбөр	- Удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог сайжруулсан - Төр, бүс нутаг, сургуулийн үүргийн хуваарилалт - Шинэ хичээл: Компьютер, хүрээлэн буй орчин, Орос хэл. Ажил мэргэжил - Гадаад хэл дээрх мэргэшсэн хичээлүүд - Бага сургуулийн англи хэл
7 дугаар шинэчлэл	1997.12.31 1998.06.31	Бага/дунд сургуулийн хөтөлбөр Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр Тусгай боловсролын хөтөлбөр Мэргэжлийн боловсролын ахлах сургуулийн хөтөлбөр	- Сурагч төвтэй сургалтын хөтөлбөр - Үндэсний сургалтын хөтөлбөр дээр суурилсан хөтөлбөр - Өөрийн сонирхсон хичээлийг сонгон судлах сургалтын хөтөлбөр - Түвшинд суурилсан сургалтын хөтөлбөр - Бие даасан үйл ажиллагааг үүсгэн байгуулах, өргөтгөх - Зорилго (чадвар) дээр суурилсан сургалтын хөтөлбөр - Бүсийн болон сургуулийн хараат бус байдлыг өргөжүүлэх

Сурах бичиг

Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг үндэсний сургалтын агуулгын хүрээнд боловсруулах бөгөөд Боловсролын яам нь зохиогчийн эрхийг эзэмшдэг, Боловсролын яамны зөвшөөрөл бүхий хувийн хэвлэх үйлдвэрүүдэд хэвлэгдэж буй сурах бичиг, Боловсролын яамнаас ач холбогдолтой, хэрэгтэй тусгай гэж хүлээн зөвшөөрсөн сурах бичгүүд гэж 3 ангилж болох юм.

Бага сургуулийн хувьд хичээл тус бүр нэг сурах бичиг үздэг байсныг нэг хичээлд олон сурах бичиг ашиглах тогтолцоонд шилжсэн. 1997 онд англи хэлний хичээл нэмэгдсэнээр ангил хэл дээрх сурах бичгүүд хэвлэгдэж эхэлсэн. Ахлах сургуулийн сурах бичгүүдийн хувьд энгийн ахлах сургууль болон мэргэжлийн болон бусад тусгай ахлах сургуулиудад зориулсан сурах бичиг гэж хувааж байна. Үүний дотор сурах бичгүүдийг үндсэн хичээлийн болон ахисан түвшний²⁸⁹ гэж 2 ангилж байна. Ихэнх үндсэн хичээлүүдийн (эх хэл, ёс зүй, түүхээс бусад) сурах бичгүүдийг боловсруулж, хэвлүүлэхэд Боловсролын яам зөвшөөрөл олгох бол ахисан түвшний сурах бичгүүдийг Боловсролын яамны захиалгын дагуу судалгааны байгууллагууд, их дээд сургуулиуд боловсруулдаг байна. Засгийн газраас баталдаг сурах бичгүүдийг Боловсролын яам зөвшөөрөл олгодог болох асуудал хэлэлцэгдэж байгаа.

Хүснэгт 4. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилд үзэх хичээлийн цаг

Хичээл		Бага сургууль						Дунд сургууль			Ахлах сургууль		
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Сургалтын	Эх хэл Урлаг	Эх хэл Урлаг	Эх хэл Урлаг	23 8	20 4	204	204	170	136	136	136	Сонго н	

²⁸⁹ advanced level

хөтөлбөр	Ёс зүй	210	238	34	34	34	34	68	68	34	34	судла х хичээ л
	Нийгмийн ухаан	Математик 120	Математик 136	102	102	102	102	102	102	136	170 (Түүх 68)	
	Математик	Ёс зүй 60	Ёс зүй 68	136	136	136	136	136	136	102	136	
	Шинжлэх ухаан	Ухаалаг амьдрал 90	Ухаалаг амьдрал 102	102	102	102	102	136	136	136	102	
	Практик сургалт	Хөгжилтэй амьдрал 180	Хөгжилтэй амьдрал 204	-	-	68	68	Техникийн боловсрол/Хөдөлмөр-гэр ахуй				
	Биеийн тамир	Бид 1-р анги 80		68	68	68	68	68	68	68	68	
	Дуу хөгжим			68	68	68	68	68	34	34	34	
	Урлаг			68	68	68	68	34	34	68	34	
	Гадаад хэл (Англи)			34	34	68	68	102	102	136	136	
Бие даан суралцах		60	68	68	68	68	68	136	136	136	204	
Тусгай арга хэмжээ		30	34	34	68	68	68	68	68	68	68	8 нэгж
Жилд үзэх хичээл (Цаг)		830	850	986	986	1,088	1,088	1,156	1,156	1,156	1,156	144 нэгж

Үндэсний өв, соёлыг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгасан байдал

1997 онд батлагдсан Боловсролын суурь хууль (*Framework Act on Education*)-ийг²⁹⁰ 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Сургуулиуд нь олон нийтийн шинжтэй байх бөгөөд шинжлэх ухаан, **соёлын өвийг хадгалж, хөгжүүлэх**, иргэдийн насан туршийн боловсролыг хөгжүүлэх бөгөөд сурагчдыг сурган хүмүүжүүлнэ.” гэж заажээ.

Ерөнхий боловсролын үндэсний хөтөлбөрт бага, дунд, ахлах сургуулийн зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна:

Бага сургуулийн хувьд:

1. бие бялдар, оюун санааны хувьд эрүүл иргэнийг хөгжүүлэх;
2. амьдрах чадварыг хөгжүүлж, янз бүрийн харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан санаа, бодлоо илэрхийлэх чадвартай болох;
3. өөрсдийн сонирхол, чадвараа таньж мэдэх;
- 4. Солонгосын өв соёл, уламжлалыг ойлгож, суралцах;**
5. Амьдралын зөв, эрүүл дадал хэвшүүлэх, хөрш болон улс орноо хайрлах.

Дунд сургуулийн хувьд:

1. эрүүл, чийрэг бие бялдар, оюун ухааныг хөгжүүлж, өөрийгөө хөгжүүлэхийн тулд арвин туршлага хуримтлуулах;
2. амьдрах, суралцахад шаардлагатай суурь мэдлэг, асуудлыг шийдвэрлэх ур чадвар эзэмшсэн байх, санаа бодлоо бүтээлчээр илэрхийлэх чадвартай болох;
3. мэдлэг, туршлага дээр тулгуурласан төрөл бүрийн талбарын ажил мэргэжлийг судлах;
- 4. Солонгосын соёлын өв, уламжлалаараа бахархаж, цаашид хөгжүүлэх;**
5. ардчиллын үнэт зүйлс, үндсэн зарчмуудыг ойлгож, ардчилсан амьдралын танин мэдэгдэхүүнтэй болох.

Ахлах сургуулийн хувьд:

1. эрүүл, чийрэг бие махбод, оюун ухааныг хөгжүүлж, амьдралыг харах өөрсдийн өнцөг, амьдралын үнэт зүйлстэй болох;
2. бүтээлч байдлаар сэтгэн, бодох, шүүмжлэх;

²⁹⁰ http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=42697&type=part&key=16

3. ажил мэргэжлийн чиг баримжааг өөрсдийн сонирхол, ур чадварт суурилан хөгжүүлэх, цаашдын боловсролд шаардагдах өргөн хүрээтэй суурь мэдлэг, чадвартай болох;
4. **даяаршсан нийгэмд Солонгосын соёл, уламжлалыг хадгалж, хамгаалж, түгээн дэлгэрүүлэх;**
5. үндэсний нийгэмлэгийн бүтээн байгуулалт, хөгжилд хувь нэмэр оруулах, дэлхийн иргэний хувьд мэдлэг, үнэт зүйлсийг хөгжүүлэх гэж тус тус заасан байна.

БНСУ-ын хувьд үндэсний өв, соёлын талаарх мэдлэгийг эх хэл, түүх, ёс зүй/ёс суртахууны хичээлийн агуулгад дараах байдлаар туссан байна.

БНСУ-ын Ерөнхий боловсролын үндэсний хөтөлбөрт бага, дунд боловсролын солонгос хэлний сургалт нь Солонгосын амин сүнс болох эх хэлээ бүтээлчээр хэрэглэх чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн байна. Энэ нь сурагчдыг эх хэлээ зөв, үр дүнтэй хэрэглэж сурснаар үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанарыг Солонгосын хөгжил, соёлыг баяжуулахад хувь нэмэр оруулна. Бага, дунд сургуулийн солонгос хэлний хичээл нь эх хэлээр ярьж, уншиж, бичиж чадвар олгохоос гадна үндэснийхээ хэл, соёлыг сонирхох сонирхлыг нэмэгдүүлэх, эх хэл, соёлоо дээдлэн хүндэтгэх, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

Ёс зүй/ёс суртахууны ухагдахуун нь 1950-иад онд анх сургалтын хөтөлбөрт туссан бөгөөд цаг үеийн нийгмийн нөхцөл, байдал, хэрэгцээ шаардлагатай уялдан хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна. БНСУ-ын анхны бие даан баталсан Сургуулийн хөтөлбөрт (1955-1963) ёс зүйн боловсрол нь нийгмийн ухааны хичээлийн агуулгад багтаж байсан. Ёс зүйн хичээлийг Боловсролын яамнаас батлагдсан журмын дагуу зааж эхэлсэн бөгөөд ёс зүйн боловсрол нь иргэний боловсролд чиглэж байсан (АНУ-ын “ардчилсан иргэний боловсрол” дээр суурилсан).

■ 1973 онд ёс суртахууны хичээл нь сургалтын хөтөлбөрт бие даасан хичээл болж орсон бөгөөд улмаар 1974 онд ахлах сургуульд ёс суртахууны хичээлээр үндэсний ёс зүйг²⁹¹ судалж эхэлсэн. Тухайн үед ёс зүйн хичээл социализмын нөлөөг эсэргүүцэх, эдийн засгийг сэргээх, үндэсний уламжлалыг сэргээхэд чиглэгдэж байсан.

■ 1973-1982 онд ёс зүйн хичээл бага, дунд сургууль болон дээд сургуульд гэсэн гурван үндсэн чиглэлээр орох болсон.

■ 1982-1988 онд уг хичээл заах арга бүрэн шинэчлэгдсэн бөгөөд хэлэлцүүлэг хэлбэрээр хичээл заагдах болсон.

■ 1989-1994 онд амьдралын ардчилсан байдал илүү тусгагдах болсон.

■ 1995-1999 онд хүнлэг байдал, итгэл үнэмшил, ёс зүйн хүмүүжлийн үндсэн төлөвшил олгогдоход чиглэсэн. Энэ үеэс хоёр Солонгос нэгдэл ба Солонгос улс нэгдсэний дараа гэсэн хоёр үеийн амьдралын зорилгыг тусгайлан заах болсон, мөн “national identity” (үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанар)-ыг томъёоллыг тусгасан.

■ 2000 оноос буюу одоо мөрдөгдөж буй 7 дугаар сургалтын хөтөлбөрт “ethnic identity” (үндэс угсаа) гэх олголт их орсон байна. 7-10-р ангийн ёс зүйн хичээлийн сурах бичиг нь 1) хувийн амьдрал, 2) гэр бүл, хөрш, сургууль дахь амьдрал, 3) нийгмийн амьдрал, 4) үндэсний болон хамт олны амьдрал²⁹² гэх 4 хэсгээс бүрдэж байна. Эдгээрт “national identity” гэж тусгайлан томъёолоогүй ч 8, 10-р ангийн сурах бичгийн 4 дахь хэсэг буюу “үндэсний болон хамт олны амьдрал”-д дээрх ойлголтыг тусгасан байна. Тухайлбал, 8-р ангийн ёс зүйн сурах бичгийн “үндэсний болон хамт олны амьдрал” хэсэг 4 бүлгээс бүрдэж байна. Үүнд:

1. **Солонгосын үндэсний хөгжил ба соёлыг эзэмшихүй** (*Korean national development and cultural fluency*);
2. **Төрийн болон үндэсний хөгжлийн ач холбогдол** (*The importance of the state and national development*);

²⁹¹ national ethics

²⁹² national and community life

3. Төр, улс үндэстнийг зөв хайрлах (*Correct love of the state and nation*);
4. Нэгдэл ба Хойд болон Өмнөд Солонгосыг нэгтгэх хүч чармайлт (*Unification and strong will for the reunification of the North and South (Korea)*).

7 дахь сургалтын хөтөлбөрт орсон ёс зүйн хичээлийг ерөнхийд нь үзвэл Солонгос үндэс угсаа, хоёр Солонгосын нэгдэл болон даяаршил гэсэн 3 асуудлыг хөндсөн байна. Хэдийгээр эдгээр асуудлууд нь өмнөх сургалтын хөтөлбөрүүдэд багтаж ирсэн хэдий ч шинэ хөтөлбөрт дээрх асуудлуудад харьцангуй их ач холбогдол өгсөн байна.



Хүснэгт 5. Ёс зүйн хичээлийн агуулга

Хичээлийн ерөнхий агуулга	3-р анги	4-р анги	5-р анги	6-р анги	7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги
- “Би” ёс суртахууны субъект болох нь	- “Ёс суртахуун”-ыг хэрхэн судлах вэ - Миний үнэ цэнэтэй амьдрал	- Шударга амьдрал - Бие даасан амьдрал	- Сэтгэл хөдлөлийн менежмент - Амьдралын тусгалууд	- Бардамнал ба өөрийгөө хөгжүүлэх - Өөрийнхөө зан авирт хариуцлага хүлээх - Зоригтой үйлдэл	(Хүн ба ёс суртахуун) - Ёс суртахууны ойлголт - Ёс суртахууны асуулт, асуудлууд - Ёс суртахууны үйлдэл	(Ажиллах, сурах) - Ажиллах, зугаацах - Сурах, ирээдүйн төлөвлөгөө - Төлөвлөгөө ба амжилт	(Амьдралын зорилго) - Өөрийгөө танин мэдэх - Аз жаргалтай амьдрал	(Хүн ба эрх чөлөө) - Эрх чөлөө ба өөрийгөө жолоодох - Ёс суртахууны үнэлгээний процесс
- Өөр хоорондоо болон нийгмийн харилцаа	- Гэр бүлээ хайрлах, бие зөв авч явах - Талархлаа илэрхийлэх - Нөхөрлөл ба найз нөхөдтэйгээ бие зөв авч	- Амлалтдаа эзэн болох - Олон нийтийн ёс зүй - Интернет ёс зүй	- Хөршүүдтэйгээ , зөв сайн харьцах - Бие биедээ туслах - Харилцан ярилцах болон зөрчлийг шийдвэрлэх - Компьютер тоглоомонд донтохоос сэргийлэх	- Хууль, дүрэм журам сахих - Ажиглалт - Зөв, шударга үйл - Бусдад санаа тавьж, ойлголцох	(Хүмүүжил ба ёс суртахуун) - Гэр бүл болон ёс суртахуун - Найз болон нөхөрлөлийн утга учир, үнэ цэнэ - Хөршүүддээ санаа тавих, халамжлах - Кибер орчин дахь ёс суртахуун	(Өсвөр үеийнхэн ба ёс суртахуун) - Өсвөр үеийнхэн, хүн чанар алдагдах асуудал - Асуудлыг энхийн замаар шийдвэрлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх - өөр хүйстэнтэй нөхөрлөх	(Хүний нэр төр, хүний эрх) - Хүний нэр төр ба цөөнхийн эрхийг хамгаалах - Жендерийн эрх тэгш байдлыг ёс суртахууны ойлголт	(Нийгмийн шударга ёс ба ёс зүй) - Нийгмийн институци ба ёс зүй - Нийгмийн ёс зүйн асуудлууд

- Улс, үндэстэн болон дэлхийн хамтын нийгэмлэг	- Улс үндэстний бэлгэ тэмдэг ба улсаа хайрлахуй - Үндэстний хоёр хуваагдсаны шалтгаан	- Улс болон үндэс угсаагаар бахархах - Хоёр улс нэгдэх шаардлага	- Хойд Солонгос дахь амьдрал болон иргэдийг ойлгох - Гадаад амьдарч буй Солонгос иргэдийг ойлгох	- Үл тэвчих байдал ба тэвчээр - Нэгдлийн алсын хараа - Тайван дэлхий	Миний амьдрал ба эх орон - Улсын алсын хараа - Улс болон өөрийгөө хөгжүүлэх	(Нэгдэл ба үндэстэн угсаатны нэгдлийн ёс зүй) - Нэгдэх хэрэгцээ, шаардлага - Хойд Солонгосын иргэд ба үндэстэн нэгтнээ хайрлах - Нэгдлийн алсын хараа	(Дэлхийн энх тайван ба хүн төрөлхтнийг хайрлах) - Бусад соёл, ёс заншлыг ойлгож, хүндэтгэх - Дэлхийн энх тайван ба хүн төрөлхтнийг хайрлахыг үйл хэрэг болгохуй	Улс, үндэстний ёс зүй - Улс ба ёс зүй - Үндэс угсаа ба ёс зүй
- Байгаль, хүрээлэн буй орчинтой харьцах харьцаа	- Хүний амьдралын үнэ цэнэ	- Байгаль орчин ба байгаль орчныг хадгалж, хамгаалах	- Жинхэнэ гоо үзэсгэлэн	- Хайр ба нигүүсэл	(Байгаль орчин ба ёс суртахуун) - Байгаль орчин ба хүний амьдрал - Байгаль орчинд ээлтэй амьдрах	(Соёл ба ёс суртахуун) - Жинхэнэ гоо үзэсгэлэн - Урлаг ба ёс суртахуун - Шинжлэх ухаан ба ёс суртахуун	(Амьдрал ба шашин) - Амьдралын хязгаар - Шашин ба ёс суртахуун	(Төгс амьдрал) - Энх тайван амьдралыг эрэлхийлэх - Төгс хүн ба төгс нийгэм

2. СИНГАПУР

Сингапур Улсын боловсролын тогтолцооны хувьд Заавал эзэмших боловсролын тухай хууль (*Compulsory Education Act, 2000*)-д заасны дагуу 2003 оноос хойш төрсөн 6-15 насны хүүхэд заавал эзэмших боловсрол эзэмшинэ. Үүнд: 6 жилийн бага боловсрол, дөрвөөс таван жилийн дунд боловсрол орох ба дараагаар нь коллеж, политехникийн сургууль, эсхүл Техникийн боловсролын институт (ТБИ)-д элсэн суралцдаг байна. Бага боловсрол нь англи хэл, эх хэл, математикт чиглэсэн нийтлэг сургалтын хөтөлбөрийг мөрддөг дөрвөн жилийн суурь шатнаас бүрдэнэ. Бага сургуульд заадаг бусад хичээлүүд нь иргэний ба ёс суртахууны боловсрол, нийгэм судлал, эрүүл мэнд, биеийн тамир, дүрслэх урлаг, хөгжим зэрэг болно. Суурь боловсролын тухай хуулийн 7-р зүйлд заасны дагуу суурь боловсрол эзэмших насны хүүхэд (6-15 нас)-ийг сургуульд хамруулаагүй эцэг, эх/асран хамгаалагчид 5000 доллар хүртэл торгууль ногдуулах, эсхүл 12 хүртэл сар хорих ял шийтгэх, эсхүл хамтад нь хэрэглэнэ.

Сингапурын боловсролын тогтолцооны үндсэн зарчим нь сурагчид тохирсон сургалт явуулах арга (*streaming*)-д суурилсан (бага сургуулийн 5 дугаар ангиас эхлэн сурагч өөрийн хэмнэлээр хөгжих боломжийг олгодог) тогтолцооноос 2008 онд судлагдахуунд суурилсан цогц тогтолцоонд шилжсэн байна. Бага сургуулийн 6 дугаар анги төгсөх үедээ бүх сурагчид англи хэл, математик, эх хэл, шинжлэх ухааны хичээлээр бага сургууль төгсөх шалгалт өгдөг байна. Шалгалтын дүнг үндэслэн сурагчдыг дунд сургуулийн түргэвчилсэн (сурагчдын 60%), энгийн академик (сурагчдын 25%), энгийн техникийн (сурагчдын 15%) гэсэн хөтөлбөрүүдэд хуваарилдаг байна.

Түргэвчилсэн хөтөлбөрийн сурагчид Боловсролын ерөнхий гэрчилгээ (GCE)-ний О түвшний шалгалт өгдөг дөрвөн жилийн хөтөлбөрөөр суралцдаг. Энгийн академик курсийн сурагчид дөрвөн жилийн GCE N-түвшинд хүрэх хөтөлбөр судлах ба тав дахь жилдээ О түвшний шалгалт өгч болдог байна. Энгийн техникийн хөтөлбөр нь дөрвөн жилийн GCE N-түвшний хөтөлбөрийн дараа сурагчдыг техникийн дээд боловсрол, ажил мэргэжил олоход, эсхүл дунд боловсролын дараах Техникийн боловсролын институтэд бэлтгэдэг байна. Их сургуульд элсэх сурагчид О түвшний шалгалтыг алгасан Интеграцчилсан хөтөлбөрийн сургуулиудад сурч болдог байна.

Гадаад хэлний сургалт

Үндсэн хуульд заасны дагуу Сингапурын албан ёсны хэл нь малай, мандарин, тамил болон англи хэл юм. Сургуулийн өмнөх болон сургуулийн боловсролын сургалтын хөтөлбөр нь англи хэл дээр суурилсан байх ба сурагчид өөрийн эх хэлээ давхар сурдаг. Эх хэл (малай, мандарин, тамил)-ий хувьд сурагчид бага, дунд сургуульдаа ахисан түвшний эх хэлний хичээлийг сонгон суралцах боломжтой бөгөөд дунд сургуульдаа тус хичээлийг үзэж суралцсан тохиолдолд дараагийн шат буюу бага коллежид үзэхгүй байж болдог. Дээрхээс гадна тодорхой шалгуур, шаардлага хангасан тохиолдолд дараах 8 хэлнээс сонгон суралцах болдог байна. Үүнд: малай (тусгай хөтөлбөр), мандарин (тусгай хөтөлбөр), бхаса-индонез, араб, франц, герман, япон болон испани хэл орж байна.

Үндэсний өв, соёлыг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгасан байдал

Сингапур Улсын хувьд үндэсний өв, соёлтой холбоотой асуудлыг *Character and Citizenship Education (CCE)* буюу Иргэний боловсролын хичээлд судалдаг байна. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн Иргэний боловсролын хичээлийн зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна.

Зорилтын 1-4 нь хувь хүний төлөвшилд чиглэсэн байна. Үүнд:

1. Хувь хүний сайн сайхан, үр дүнд хүрэхийн тулд өөрийгөө ойлгуулах, өөрийгөө удирдах чадварыг эзэмшүүлэх;
2. Ёс суртахууны зарчмуудыг дээдэлсэн, шударга зарчмыг баримтлан хариуцлагатай шийдвэр гаргах;
3. Хүмүүсийн харилцан хүндэтгэл дээр суурилсан эерэг харилцааг бий болгоход нийгмийн ухамсар, харилцааны чадварыг ашиглах;
4. Уян хатан байж, сорилт бэрхшээлүүдийг боломж болгох чадвартай байх;

Зорилтын 5-8 нь 21-р зууны иргэнийг удирдлага болгон нийгмийн гишүүний хувьд соёлтой, идэвхтэй, хариуцлагатай иргэн болгоход чиглэсэн байна. Үүнд:

5. **Улс улс үндэстнээ байгуулахад оролцох, үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанарын (national identity) бахархал;**
6. **Сингапурын нийгэм-соёлын олон янз байдлыг ойлгон үнэлж, нийгмийн нэгдмэл байдал, эв нэгдлийг хөхүүлэн дэмжих, хамгаалах;**
7. Бусдын төлөө санаа тавьж, нийгэм, улс үндэстнийхээ хөгжил дэвшилд идэвхтэй хувь нэмэр оруулах;
8. Олон нийт, үндэсний болон дэлхийн асуудлуудад хариуцлагатай, мэдээлэлтэй иргэний хувиар хандах, байр сууриа илэрхийлэх.

Иргэний боловсролын хичээлийн бага, дунд, их сургуулийн өмнөх (pre-university) сургуульд үзэх нийт цаг, агуулга

Иргэний боловсролын хичээлийн бүрэлдэхүүн	Агуулга
Иргэний боловсролын хичээл (ИБ)	Бага сургууль Үнэ цэнэ, мэдлэг, чадвар болон иргэний боловсролын хичээлийн эх хэл дээр зааж сургах Дунд сургууль Үнэ цэнэ, мэдлэг, чадвар болон иргэний боловсролын хичээл
Form Teacher Guidance Period (FTGP)	Нийгмийн үр чадвар болон сэтгэл хөдлөлөө удирдах чадвар эзэмшүүлэх (үүнд цахим орчин дахь аюулгүй байдал болон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох) ба багш сурагчийн харилцаа
Сургуульд суурилсан иргэний боловсрол (School-based CCE)	Сургуулийн үнэ цэнэ, сургуулиас зохион байгуулах арга хэмжээг багтана
Иргэний боловсролын хичээлийн удирдамжийн модуль (CCE guidance module)	<ul style="list-style-type: none"> • Мэргэжил сонгох (ECG) • Цахим орчин дахь аюулгүй байдал (CW) • Эрүүл мэндийн сургалт (SEd)

Бага сургуулийн хувьд:

1-3-р анги	ИБ-ын хичээл 30 цаг	FTGP 15 цаг	School-based CCE 15 цаг	Жилд 60 цаг
4-р анги	ИБ-ын хичээл 45 цаг	FTGP 15 цаг	School-based CCE 15 цаг	Жилд 75 цаг
5-6-р анги	ИБ-ын хичээл 45цаг	FTGP 15 цаг	4 цаг School-based CCE 11 цаг	Жилд 75 цаг

Дунд сургуулийн хувьд:

1-5-р анги	ИБ-ын хичээл 20 цаг	CCE guidance module 13 цаг	School-based CCE 27цаг	Жилд 60 цаг
------------	---------------------	----------------------------	------------------------	-------------

Их сургуулийн өмнөх боловсролын хувьд (Pre-university):

2-3-жил	ИБ-ын хичээл 40 цаг	Cohort level CCE 40 цаг	Customized CCE learning experoence	2-3 жилд 80 цаг
---------	---------------------	-------------------------	------------------------------------	-----------------

Хүснэгт 6. Иргэний боловсролын хичээлийн агуулга

Д/д	Иргэний боловсролын хичээлийн зорилго	Зорилго (Боловсролын шат тус бүрт)			Гол үнэт зүйл
		Бага	Дунд	Их сургуулийн өмнөх	
1	Хувь хүний сайн сайхан, үр дүнд хүрэхийн тулд өөрийгөө ойлгуулах, өөрийгөө удирдах чадварыг эзэмшүүлэх;	Хөдөлмөрөөрөө бахархах	Сурч боловсрох хариуцлагаа ухамсарлах	Төгс төгөлдрийг илэрхийлэхдээ зорилготой байх	Хариуцлага
		Зөв дадал зуршил, урлагийн талаарх мэдлэгтэй болох	Биеийн тамираар хичээллэх, урлагийн талаарх мэдлэгтэй болох	Эрүүл амьдралын хэв маягийг эрэлхийлэх, гоо зүйн мэдрэмжтэй болох	
2	Ёс суртахууны зарчмуудыг дээдэлсэн, шударга зарчмыг баримтлан хариуцлагатай шийдвэр гаргах;	Буу, зөвийг ялгах чадвартай байх	Ёс суртахуунтай байх	Зөв гэсний төлөө тэмцэх ёс суртахууны зоригтой байх	Хариуцлага, шударга байдал
3	Хүмүүсийн харилцан хүндэтгэл дээр суурилсан эерэг харилцааг бий болгоход нийгмийн ухамсар, харилцааны чадварыг ашиглах;	Бусадтай хамтран ажиллах, хуваалцах, асран халамжлах чадвартай байх	Багаар ажиллаж, бусдад санаа тавих	Нийгмийн хариуцлагатай байж, янз бүрийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллах чадвартай байх	Хүндлэл
4	Уян хатан байж, сорилт бэрхшээлүүдийг боломж болгох чадвартай байх;	Өөрийн хүч чадал, давуу талаа хөгжүүлэх	Өөрийн ур чадвар, чадалдаа итгэж, өөрчлөгдөж чаддаг байх	Саад бэрхшээлийг даван туулах чадвартай байх	Уян хатан байдал
		Юмс үзэгдлийг сонирхох	Бүтээлч сэтгэлгээтэй байх	Шинэлэг, ажил хэрэгч байх	
5	Улс улс үндэстнээ байгуулахад оролцох, “national identity” (үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанар)-ын бахархал;	Улс орноо таньж мэдэх, хайрлах	Улс орондоо итгэх итгэл ба юу чухал болохыг ойлгох	Сингапурын иргэн байхын бахархал, дэлхий дахин дахь Сингапурын байр суурийг ойлгох	Хариуцлага
6	Сингапурын нийгэм-соёлын олон янз байдлыг ойлгон үнэлж, нийгмийн нэгдмэл байдал, эв нэгдлийг хөхүүлэн дэмжих, хамгаалах;	Бусадтай хамтран ажиллах, хуваалцах, асран халамжлах чадвартай байх	Багаар ажиллаж, бусдад санаа тавих	Нийгмийн хариуцлагатай байж, янз бүрийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллах чадвартай байх	Хариуцлага, эв нэгдэл
		Өөртөө итгэлтэйгээр өөрийгөө илэрхийлэх, сэтгэж бодох	Олон янзын үзэл бодлыг ойлгож, харилцах чадвартай байх	Шүүмжлэлтэйгээр бодож, үнэмшилтэйгээр харилцах чадвартай байх	
7	Бусдын төлөө санаа тавьж, нийгэм, улс үндэстнийхээ хөгжил дэвшилд идэвхтэй хувь нэмэр оруулах;	Өөрийн хүч чадал, давуу талаа хөгжүүлэх	Өөрийн ур чадвар, чадалдаа итгэж, өөрчлөлтөд дасан зохицох чадвартай байх	Саад бэрхшээлийг даван туулах чадвартай байх	Хариуцлага, халамж
		Бусадтай хамтран ажиллах, хуваалцах, асран халамжлах чадвартай байх	Багаар ажиллаж, бусдад санаа тавих	Нийгмийн хариуцлагатай байж, янз бүрийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллах чадвартай байх	
		Юмс үзэгдлийг сонирхох	Бүтээлч сэтгэлгээтэй байх	Шинэлэг, ажил хэрэгч байх	
8	Олон нийт, үндэсний болон дэлхийн асуудлуудад хариуцлагатай, мэдээлэлтэй иргэний хувиар хандах, байр сууриа илэрхийлэх.	Буу, зөвийг ялгах чадвартай байх	Ёс суртахуунтай байх	Зөв гэсний төлөө тэмцэх ёс суртахууны зоригтой байх	Хүндлэл, хариуцлага
		Өөртөө итгэлтэйгээр өөрийгөө илэрхийлэх, сэтгэж бодох	Олон янзын үзэл бодлыг ойлгож, харилцах чадвартай байх	Шүүмжлэлтэйгээр бодож, үнэмшилтэйгээр харилцах чадвартай байх	
		Улс орноо таньж мэдэх, хайрлах	Улс орондоо итгэх итгэл ба юу чухал болохыг ойлгох	Сингапурын иргэн байхын бахархал, дэлхий дахин дахь Сингапурын байр суурийг ойлгох	

3.ЯПОН

Эрх зүйн орчин²⁹³

Японы Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд “Бүх хүн хуульд заасны дагуу өөрийн ур чадварт тохирсон тэгш боловсрол эзэмших эрхтэй. Бүх хүн өөрийн асран хамгаалалтад байгаа хүүхдийг хуульд заасан ерөнхий боловсролтой болгох үүрэгтэй. Заавал эзэмших боловсрол үнэ төлбөргүй байна” гэж заажээ.

Үндсэн хуульд заасан энэ бодлогод тулгуурлан 1947 оны 3 дугаар сард Боловсролын суурь хуулийг баталсан бөгөөд тус хуулиар боловсролын салбарт баримтлах дараах дөрвөн зарчмыг дэвшүүлэн тавьсан байна. Үүнд:

- ✓ Хүмүүжүүлэх зорилгод тулгуурласан боловсролын бодлого;
- ✓ Боловсролын тэнцүү боломж ба хүйсийн тэгш байдал;
- ✓ Сургуулийн ардчилсан, үл ялгаварлах тогтолцоо;
- ✓ Үнэ төлбөргүй олгох заавал эзэмших боловсролын 6-3 тогтолцоо (6 жилийн бага сургууль, 3 жилийн дунд сургууль).

Мөн хуулиар сургуулийн насны бүх хүүхдэд заавал эзэмших боловсрол буюу 9 жилийн боловсролыг үнэ төлбөргүй олгох, нийгмийн боловсрол, гэр бүлийн боловсрол олгох тухай зохицуулалт, улс төрийн боловсрол, шашны боловсрол олгоход хориглох зарим зохицуулалтыг тус тус тусгасан байна. Мөн үндэсний болон орон нутгийн боловсролыг зүй зохисгүй байдлаар хянахыг хориглосон байна.

Боловсролын суурь хуульд хамгийн сүүлд 2006 оны 12 дугаар сард нэмэлт, өөрчлөлт орсон байх бөгөөд боловсролыг тойрсон асуудал, шинжлэх ухаан, технологийн дэвшил, мэдээллийн дэвшилтэт технологи, хөгширч буй нийгэмд нөлөөлж буй байдал, гэр бүлийн амьдралын хэв маяг, хүүхдийн хүрээлэн буй орчны өөрчлөлт зэрэг олон асуудлууд урган гарснаар зайлшгүй нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тулгарсан байна.

Гэхдээ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа өмнөх хуулиар тогтоосон нийтлэг зарчим, Японы уламжлал, соёлыг уламжлан үлдээсэн байна. Хуульд заасан боловсролын суурь бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 2008 оны 07 дугаар сард Засгийн газраас “Боловсролыг дэмжих үндсэн төлөвлөгөө”-г боловсруулан баталсан. Энэ төлөвлөгөөг 10 жил тутам гаргахаар тогтсон ба уг төлөвлөгөөгөөр дараагийн 10 жилд хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тогтоодог. Бусад бүх төсөл, хөтөлбөр үндсэн чиглэл буюу төлөвлөгөөтэй уялдан хэрэгжиж байгаа нь тухайн улсын боловсролын салбар цэгцтэй, ойлгомжтой, үр нөлөө өндөртэй хөгжиж байгаагийн илрэл юм.

Тус улсад одоогоор Боловсролын суурь хуульд нийцүүлэн баталсан дараах хуулиуд үйлчилж байна. Үүнд:

- Сургуулийн боловсролын тухай хууль *School Education Law* (сургуулийн зохион байгуулалт, менежментийг зохицуулсан);
- Нийгмийн боловсролын тухай хууль *Social Education Law* (нийгмийн боловсролын үйл ажиллагааг зохицуулсан);
- Орон нутгийн боловсролын байгууллага болон орон нутгийн боловсролын удирдлагын тухай хууль *Law Concerning Organization and Functions of Local Educational Administration*.

Ерөнхий боловсролын тогтолцоо²⁹⁴

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн яам нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага юм. Яам нь боловсролын салбарын нэгдсэн бодлого боловсруулж тогтоох, сургалтын хөтөлбөр боловсруулах, багш, ажилчдын цалингийн хэмжээг тогтоох, муж, орон нутгийн сургуулийн санхүүжилт олгох, Японы боловсролын бүх үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг ажлыг хариуцдаг байна.

Японд улсын болон хувийн сургууль үйл ажиллагаа явуулдаг. Ихэнх улсын

²⁹³ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн яамны цахим хаяг
<http://www.mext.go.jp/en/policy/education/overview/index.htm>

²⁹⁴ Timss & pirls international study center
<http://timssandpirls.bc.edu/timss2015/encyclopedia/countries/japan/>

сургуулийн санхүүжилтийг Засгийн газраас санхүүжүүлж, орон нутгийн сургуулийн санхүүжилтийг тухайн орон нутгаас санхүүжүүлдэг. Гэхдээ засгийн газраас орон нутгийн сургуульд зарим санхүүжилт олгодог байна.

Харин хувийн сургууль нь сургалтын төлбөр, хандив, бизнесийн хөрөнгө оруулалтаас санхүүждэг боловч Засгийн газраас мөн бага хэмжээний санхүүжилт олгодог.

Японд бага ангийн сурагчдын 1.1 хувь, дунд ангийн сурагчдын 7 хувь, ахлах ангийн сурагчдын 31.1 хувь нь хувийн сургуульд суралцдаг байна.

Тус улс нь 6-3-3 загвар буюу 6 жилийн бага сургууль (*shogakko*), 3 жилийн дунд сургууль (*chugakko*), 3 жилийн ахлах сургууль (*kotogakko*) гэсэн ерөнхий боловсролын тогтолцоотой. Заавал эзэмших боловсролд бага болон дунд боловсрол ордог. Нийт 6-15 насны хүүхдүүдийн 96-98 хувь нь ерөнхий боловсрол эзэмшсэн байдаг.

Японы тусгай хэрэгцээт ерөнхий боловсролын сургуульд харьцангуй хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцдаг. 2007 оноос зөвшөөрөгдсөн зарим энгийн ерөнхий боловсролын сургуулиуд тусгай ангитай болсон ба энэ ангид хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцдаг байна. Мөн эмнэлэгт хэвтэж буй өвчтэй хүүхдүүдэд зориулсан ангийг эмнэлэгт байгуулсан байдаг байна.

Японы боловсролын тогтолцооны онцлог нь бага болон дунд ангид албан ёсны шалгалт авч, дүн тавьдаггүй харин ахлах ангид элсэн орохдоо шалгалт өгдөг байна. Мөн хүүхдүүдийг чадвараар нь төрөлжсөн анги болгож хуваадаггүй ба бүх хүүхэд тэгш боловсрол эзэмших ёстой гэсэн зарчмыг баримталдаг. Үүнээс гадна амжилттай суралцах нь төрөлхийн оюун ухаанаас илүү тухайн хүүхдийн хичээл зүтгэл, хөдөлмөр хамгийн чухал гэж үздэг. Мөн тухайн хүүхдийн сурлагын амжилтад эцэг эх, багш, сурагч гэсэн гурвалсан холбоо хамгийн чухал ба сурагч амжилт гаргаагүй бол эцэг эх, багш, сурагчийн аль аль нь хариуцлага хүлээнэ. Энэ тогтолцоо нь сурагч болон багш, эцэг эхийн хариуцлагыг дээшлүүлдэг байна.

Мөн тус улс нь боловсролын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээнд бус тухайн салбарт хуваарилагдаж буй хөрөнгө оруулалтыг зөв, оновчтой хуваарилахад онцгой анхаардаг. Үүний нэг илрэл нь тухайн салбарт хуваарилагдаж буй хөрөнгө оруулалтын ихэнх нь багшийн хөгжил, сурагчийн хөгжилд зориулагддаг бол сургуулийн барилга, тоноглол, сурах бичиг зэрэг нь хамгийн энгийн, өртөг багатай байдаг байна.

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр

Яамнаас боловсруулсан сургалтын хөтөлбөрийг улсын хэмжээнд удирдамж болгон мөрдөх үүрэгтэй ба энэхүү сургалтын хөтөлбөрийн агуулгыг нарийвчлан тогтоож өгдөг. Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа эхлээд бүрэн эзэмших ёстой сэдвүүдийг жил бүрээр зааж өгч, жилээс жилд дэвшил гаргана гэж тооцсоны дагуу хөтөлбөрийн уялдаа холбоонд маш өндөр ач холбогдол өгч боловсруулдаг байна. Яамнаас хөтөлбөрт зориулан сургуулийн түвшинд ашиглах гарын авлагыг хичээл тус бүрээр боловсруулж хэвлэдэг.

Японы сурах бичгүүд товч бөгөөд цомхон байдаг. Мөн маш хямд өртгөөр бүтсэн, 100 аас ихгүй хуудастай нимгэн хавтастай ном байдаг. Тухайн хичээл дээр улирал бүр 1 сурах бичиг хэрэглэх ба сурах бичгийн агуулга нь хамгийн гол ухагдахуунуудад анхаарсан байдаг.

Бага ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, амьдрах орчин, хөгжим, зураг, гар урлал, биеийн тамир, гэрийн аж ахуй гэсэн хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр **ёс суртахууны хичээл** ордог.

Дунд ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, хөгжим, зураг, биеийн тамир, үйлдвэрлэлийн урлаг, гэрийн аж ахуй, **гадаад хэл**, сонгон судлах хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр **ёс суртахууны хичээл** орно.²⁹⁵

Японд гадаад хэлийг 7-р ангиас нь зааж эхэлдэг. Гадаад хэл заах тухайд Япон хэл, соёлыг бүрэн танин мэдсэний дараа гадаад хэл заах нь үр дүнтэй гэсэн бодлогыг

²⁹⁵ <https://www.nuffic.nl/en/publications/find-a-publication/education-system-japan.pdf>

баримталдаг байна.²⁹⁶

1-ээс 6 дугаар ангийн хичээлийн үргэлжлэх хугацаа 45 минут, 7-оос 9 дүгээр ангийн хичээлийн үргэлжлэх хугацаа 50 минут байдаг.

Хүснэгт 7. Бага болон дунд ангид судлах хичээлийн цаг²⁹⁷

ХИЧЭЭЛИЙН ТӨРӨЛ	АНГИ								
	1	2	3	4	5	6	7	8	9
Япон хэл	272	280	235	235	180	175	140	140	105
Нийгэм судлал	-	-	70	85	90	100	105	105	140
Тоо бодлого	114	155	150	150	150	150	-	-	-
Математик	-	-	-	-	-	-	140	105	140
Шинжлэх ухаан	-	-	70	90	95	95	105	140	140
Амьдрах орчин	102	105	-	-	-	-	-	-	-
Хөгжим	68	70	60	60	50	50	45	35	35
Зураг, гар урлал	68	70	60	60	50	50	-	-	-
Өрхийн эдийн засаг	-	-	-	-	60	55	-	-	-
Биеийн тамир	90	90	90	90	90	90	-	-	-
Уран зураг	-	-	-	-	-	-	45	35	35
Эрүүл мэнд, биеийн тамир	-	-	-	-	-	-	105	105	105
Үйлдвэрлэлийн урлаг, гэрийн урлаг	-	-	-	-	-	-	70	70	35
Гадаад хэл	-	-	-	-	-	-	140	140	140
Ёс суртахуун	34	35	35	35	35	35	35	35	35
Дүгнэлт хичээл	-	-	105	105	110	110	50	70	70
Сонгон судлах хичээл	34	35	35	35	35	35	35	35	35
НИЙТ /ЖИЛД/	782	840	910	945	945	945	1015	1015	1015

Сургалтын хөтөлбөр, агуулгад үндэсний өв, соёлыг тусгасан байдал

1890 онд Эзэн хаан Боловсролын тухай зарлиг гаргасан ба энэхүү зарлигаар зайлшгүй эзэмших шинэ боловсролын тогтолцооны өөрчлөлтөд Японы үнэт зүйлийг гол болгон баримтална гэж тунхагласан байна. Энэ нь үнэнч зүтгэл, ахмадын хүндэл, гэр бүлийн гишүүд, хань ижил, анд нөхөдтэй тогтоосон харилцаа зэрэг ёс суртахууны чанаруудыг чухалчлахыг сануулсан зарлиг байсан юм.

Японы суурь боловсролын тухай хуулиар ёс суртахуун, ёс зүйн боловсролыг заавал эзэмшүүлэх албан боловсрол гэж заасан ба энэ нь Японы үндэсний өв, соёлтой салшгүй холбоотой юм.

Ёс зүйн боловсрол нь тухайн сурагч Япон орны үнэт зүйлийг таньж ойлгох, улмаар өөрийн орны соёл, уламжлалыг хадгалах, үнэт зүйлээ өвлүүлэн авч явах иргэнийг төлөвшүүлэх зорилготой юм. Иймд ерөнхий боловсролын сургуульд ёс зүй, ёс суртахууны боловсрол олгоход маш их анхаардаг байна.

Ерөнхий боловсролын сургуульд ёс суртахууны хичээлийг дараах 4 төрлийн агуулгад тулгуурлан заадаг.²⁹⁸

1. Өөрийнхөө тухай: Хүн бүр бие даасан байх, өөрсдийн хийж чадах зүйлээ хийх, хэм хэмжээтэй амьдрах.
2. Бусад хүмүүстэй харилцах харилцаа: Хүмүүстэй шударга харилцах, хүмүүстэй эелдэг харилцах.
3. Байгаль, эрхэм дээд зүйлтэй харилцах: Байгалийн гамшиг, байгаль, амьтны ач холбогдлыг мэдрэх.
4. Нийгэм болон бүлгүүдийн тухай: Олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, дүрэм журмаа дагах, амлалтаа биелүүлэх.

²⁹⁶ Сургуулийн өмнөх ба бага боловсролын түвшинд гадаад хэл зааж эхлэх насыг хуульчлан тогтоох боломж, жишиг. Лавлагаа мэдээлэл. УИХ-ын Тамгын газар, Судалгаа, шинжилгээний хэлтэс. Эмхэтгэл 17.

²⁹⁷ Moral education in Japan <https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303MED.pdf>

²⁹⁸ Moral education in Japan <https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303MED.pdf>

4.ФИНЛАНД

Ерөнхий боловсролын тогтолцоо

Финланд Улс нь PISA-ийн бүх үнэлгээнд тэргүүн эгнээнд тогтмол эрэмбэлэгддэг боловсролын тогтолцоогоор дэлхийд тэргүүлэгч улсын нэг юм.

1960-аад оны сүүл үе хүртэл нийт иргэдийн 60 орчим хувь нь хөдөө амьдарч, хүүхэд залуусын ихэнх нь 6 жилийн боловсрол буюу бага боловсрол эзэмшиж байсан ба тухайн үед бага, дунд сургууль нь тусдаа үйл ажиллагаа явуулж байсан байна.

Парламентаас боловсролын тогтолцоондоо шинэчлэл хийх зорилгоор 3 удаа комисс байгуулж ажилласан ба комисс тус бүрээс гарсан зөвлөмжид “Финландын бүх хүүхэд сурч боловсроход тэнцүү боломжоор хангах, үүнд нийцсэн боловсролын тогтолцоо бий болгох” талаар зөвлөмжүүдийг гаргасан байх ба үүний дагуу 1968 оны 11 дүгээр сард 9 жилийн (бага, дунд сургуулийг нийлүүлсэн) сургууль бүхий Суурь боловсролын тухай хуулийг баталсан байна. Шинээр батлагдсан Суурь боловсролын тухай хууль нь 1972 оноос шат дараатайгаар хэрэгжин, 1977 он гэхэд орон даяар шинэ тогтолцоонд шилжиж дууссан байна. Энэхүү хууль батлагдсанаар Финландын боловсролын тогтолцоо үндсээрээ өөрчлөгдсөн байна.

Тус улсын Боловсрол, соёлын яамны харьяа Боловсролын үндэсний зөвлөл нь ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, насанд хүрэгчдийн боловсролын зорилго, агуулга, арга барилыг хөгжүүлэх үүрэгтэй мэргэжлийн байгууллага юм. Тус зөвлөл нь Үндэсний сургалтын хөтөлбөрийг боловсруулж, батлах мөн боловсролын системийг үнэлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Финланд нь засаг захиргааны 6 мужид хуваагддаг ба муж тус бүр Боловсрол, соёлын яаманд харьяалагдах Боловсрол, соёлын газартай байна.²⁹⁹

Тус улсын ерөнхий боловсролын тогтолцоонд чанартай, үр ашигтай, тэгш боломжоор хангасан, өрсөлдөх чадвартай байх зэрэг үндсэн зарчмуудыг баримталдаг байна. Финланд хүүхдүүд хуульд заасны дагуу 6 настайдаа бэлтгэл ангид заавал явах үүрэгтэй ба үүний дараа 7 настайдаа 1 дүгээр ангид элсэн ордог байна. Бага, дунд шатны сургуулийг 9 жилийн бүрэн дунд сургууль гэнэ. Заавал эзэмших боловсролд бага, дунд боловсрол ордог. Бүрэн дунд сургууль төгссөн сурагч 3 жилийн ахлах сургууль, эсхүл 3 жилийн техник мэргэжлийн сургуульд элсэн орох боломжтой.

Финландад хувийн болон улсын сургууль байдаг боловч хувийн сургуулиудад улсын сургуультай адил хэмжээний санхүүжилтийг улсаас олгоно. Мөн хувийн сургуулиудад нь сургалтын төлбөр авахыг хориглосон ба элсэлтийн хувьд улсын сургуулийнхтай адил шаардлага тавьж, сурагчдыг сонгон шалгаруулахад тусгай шаардлага, нөхцөл тавихыг хориглодог байна.

Ерөнхий боловсролын сургууль жилд 190 цаг буюу өдөрт 4 цаг хичээллэдэг ба энэ нь бусад оронтой харьцуулахад харьцангуй бага цаг юм.

Финланд сурагчдын сурлагын амжилтад багшийн чанар, ур чадвар чухал үүрэгтэй байдаг. Засгийн газраас багшлах ажилд мэргэжлийн өндөр босго тогтоож, багш бэлтгэх сургалтын хугацааг уртасгаж, сурагчдын хяналтын үүргийг багш нарт олгосон нь мэргэжлийн хувьд илүү бие даасан байдалтай болж багшийн мэргэжлийг нэр хүндтэй мэргэжил болгож чадсан байна. Энэ нь нийгэм дэх тэдний байр суурийг дээшлүүлж улмаар багш бэлдэх хөтөлбөрт авьяастай, тэмүүлэлтэй засуулын тогтвортой урсгалыг татаж чадсан байна.

Тус улсад үндэсний онцлогоос шалтгаалан сургуулиуд нь харьцангуй жижиг буюу цөөн тооны (300 орчим) сурагчтай, нэг анги дунджаар 20 хүүхэдтэй байдаг. Сурагч өөрийн гэрт хамгийн ойрхон сургуульд суралцах ба эцэг, эхийн хүсэлтээр өөр сургуульд суралцах боломжтой.

²⁹⁹ Юнескогийн Олон Улсын боловсролын лавлах
http://www.ibe.unesco.org/fileadmin/user_upload/archive/Countries/WDE/2006/WESTERN_EUROPE/Finland/Finland.htm

Мөн сурагчдын эрүүл, аюулгүй, тав тухтай орчинг бүрдүүлэхэд онцгой анхаарч, илчлэг өндөртэй өдрийн хоол, эрүүл мэнд болон шүдний эмнэлгийн үйлчилгээ, тусламж хэрэгтэй сурагчдад нэмэлт үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг байна. Боловсролоос гадна эдгээр иж бүрэн үйлчилгээг үзүүлэх нь тухайн сурагч амжилттай суралцах нөхцөлийг бүрдүүлж, Финландын сурагчдын сурлагын амжилт ерөнхийдөө жигд өндөр үзүүлэлттэй байдгийн нэг шалтгаан нь юм гэж үздэг байна.

Мөн Финландын тусгай боловсрол шаардлагатай сурагчдын 50 хувь нь энгийн сургуульд суралцдаг ба энэ нь бусад оронтой харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт юм. Сургууль бүр тусгай хэрэгцээт сурагчдад зориулсан багштай ба эдгээр багш нар тусгай хэрэгцээт сурагчдыг энгийн сурагчидтай хамт сургахад шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, ангийн сурагчдаасаа сурлагаараа хоцрохоос сэргийлэх арга хэмжээ авч ажилладаг.³⁰⁰

Сургалтын хөтөлбөр

Ерөнхий боловсролын асуудал эрхэлсэн Боловсролын үндэсний зөвлөлөөс үндэсний хэмжээнд мөрдөх үндсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулдаг ба энэхүү хөтөлбөрт хичээлийн сэдвүүдийн ерөнхий агуулга болон зорилтуудыг тусгасан байдаг. Үндсэн сургалтын хөтөлбөрийн дагуу муж бүр сургалтын хөтөлбөрөө боловсруулна, мужийн сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сургууль бүр сургалтын хөтөлбөрөө боловсруулж мөрддөг. Үндсэн сургалтын хөтөлбөрт 10 жил тутам буюу 1985, 1994, 2004 болон 2014 онуудад шинэчлэл хийн мөрдөж байна.

Суурь боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлд Боловсролын агуулгыг дараах байдлаар томъёолсон байна.³⁰¹

4. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр нь 14-р зүйлд заасны дагуу батлагдсан байх ба, үүнд дараах гол хичээлүүд багтана: эх хэл, уран зохиол, хоёр дахь эх хэл, гадаад хэл, хүрээлэн буй орчны судалгаа, эрүүл мэндийн боловсрол, шашны боловсрол болон ёс зүй, түүх, нийгмийн ухаан, математик, физик, хими, биологи, газар зүй, биеийн тамир, хөгжим, дүрслэх урлаг, гар урлал мөн өрхийн эдийн засаг зэрэг хичээлүүд.
5. Сурагч нь сургалтын хөтөлбөрт тодорхойлсны дагуу 1-р хэсэгт дурдсанаас бусад үндсэн суурь боловсролын хичээлийг заалгах, эдгээр хичээлүүдийн заримыг нь, эсхүл бүгдийг сонгох зэрэг чөлөөтэй сонгон суралцах боломжтой.

Мөн хуулийн 14 дүгээр зүйлд Үндсэн сургалтын хөтөлбөр болон хичээлийн цагийн хуваарийг дараах байдлаар тусгасан байна.

1. Засгийн газар энэхүү хуульд заасан үндэсний боловсролын ерөнхий зорилго болон хичээлийн заавар зөвлөмж, хичээлийн групп/бүлэг болон хичээлүүдийг заах цагийн хуваарийг тодорхойлно.
2. Боловсролын үндэсний зөвлөл нь энэ хуульд заасан сургалтын хөтөлбөрүүд, заавар зөвлөгөө болон бусад боловсролд хамаарах зорилт, хичээлүүдийн үндсэн агуулга болон орон нутгийн боловсролын байгууллагын харьяаллын хүрээнд гэр-сургуулийн хамтын ажиллагаа, сурагчдын халамжийн үндсэн зарчим зэргийг тус, тус тодорхойлно.
3. Сургуулийн өмнөх боловсролын хувьд, 2-р дэд бүлэгт дурдсан хичээлийн цагийн хуваарийг Боловсролын яам, Нийгэм эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулна. Сургуулийн өмнөх боловсрол, сурагчдын халамжийн болон гэрийн сургуулийн хамтын ажиллагаа зэрэг дэд хэсгийн 2-т дурдсан гол хөтөлбөрийн тухай шийдвэрийг Боловсролын үндэсний зөвлөл шийднэ.

Мөн хуулийн 15 дугаар зүйлд: Боловсрол олгогч байгууллага нь энэ хуульд заасан сургалтын хөтөлбөрийг батална. Финланд, Швед, сами болон бусад хэл дээр явагдах боловсролын хөтөлбөр тус бүрээр тусдаа хөтөлбөр батална.

³⁰⁰ Финландын боловсролын тогтолцооны товч мэдээлэл
http://www.oph.fi/download/146428_Finnish_Education_in_a_Nutshell.pdf

³⁰¹ Финландын Суурь боловсролын тухай хууль <https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1998/en19980628.pdf>

Дээрх хуулийн зохицуулалтын дагуу Засгийн газраас нийтлэг сэдвийн хүрээнд тухайн жилийн 7 хоногт үзэх хичээл, цагийн хуваарийг баталдаг. Энэ хуваарь нь жишиг хуваарь бөгөөд Үндэсний сургалтын хөтөлбөрт нийцүүлэн муж болон сургуулиуд хичээл, цагийн хуваариа өөрсдөө батлах эрхтэй байдаг. Хэдийгээр 1-6 дугаар ангийн сурагчид ижил программаар хичээллэх ёстой боловч цаг болон хичээл сонголтын уян хатан бодлогын хүрээнд муж болон сургуулиуд өөр өөр сэдэв дээр төвлөрч болдог. Мөн нэмэлт судлах хичээлийг эцэг эх, асран хамгаалагч сонгох эрхтэй байдаг.

Финландын сургалтын хөтөлбөрийн бас нэг онцлог нь Үндсэн хуулийн 17 дугаар хэсэгт заасны дагуу албан ёсны Финланд, Швед хоёр хэлтэй байдагт оршино. Иймд тухайн сурагч өөрийн эх хэлээ үзэхээс гадна албан ёсны 2 дахь хэлийг 6 дугаар ангиасаа үзэхээр хөтөлбөрт тусгасан байдаг. Гэхдээ тухайн мужийн онцлогоос шалтгаалан мужийн сургалтын хөтөлбөрт эрт заахаар тусгасан бол аль ч ангиас эхлэн суралцах боломжтой.

Харин гадаад хэлийг Засгийн газраас баталсан хуваарийн дагуу 3 дугаар ангиас албан ёсоор үзэхээр тусгасан байдаг ч мөн мужийн онцлогоос шалтгаалан мужийн сургалтын хөтөлбөрийн дагуу аль ч ангиас эхлэн суралцах боломжтой.

Хүснэгт 8. Бага, дунд ангид судлах хичээлийн цаг³⁰²
(7 хоногт үзэх хичээлийн цаг)

ХИЧЭЭЛИЙН НЭР	АНГИ									Нийт цаг
	1	2	3	4	5	6	7	8	9	
Эх хэл, уран зохиол	14			18			10			42
Гадаад хэл				9			7			16
2 дахь албан ёсны хэл						2	4			6
Математик	6			15			11			32
Байгаль орчин	4			10						
Биологи, газар зүй							7			
Физик, хими							7			
Эрүүл мэнд							3			
Байгаль орчин, байгалийн судалгаа			14				17			31
Шашин, ёс зүй	2		5				3			10
Түүх, нийгэм			5				7			12
Хөгжим	2		4				2			8
Дүрслэх урлаг	2		5				2			9
Гар урлал	4		5				2			11
Биеийн тамир	4		9				7			20
Өрхийн эдийн засаг							3			3
Урлаг болон сонгон судлах хичээл сонгоход			6				5			11
Урлаг болон сонгон судалсан хичээлд нийтдээ										62
Зөвлөгөө өгөх							2			2
Нэмэлт сэдэв					9					9
Нэмэлтээр гадаад хэл						12				12
Нэмэлтээр 2 дахь эх хэл							4			4
Нийт хамгийн багадаа судалбал зохих цаг										222

5.НОРВЕГ

Норвег Улс нь “Бага, дунд боловсролын тухай хууль”-ийг (Боловсролын тухай хууль)³⁰³ 1998 онд баталсан бөгөөд 2010-2014 онд нэмэлт, өөрчлөлтүүд оруулсан байна.

Норвегийн боловсролын бодлого нь нийгэм-соёл, оршин суугаа газраас үл хамааран нийгмийн бүх гишүүдэд эрх тэгш боловсрол олгох зарчимд суурилдаг. Боловсролын байгууллагуудын гол зорилго нь мэдлэг, соёлын ур чадварыг дээшлүүлэхээс гадна иргэдийн нийгмийн хэрэгцээг хангаж, нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх явдал

³⁰² Засгийн газрын тогтоол, 2012.06.28

http://www.oph.fi/download/179422_distribution_of_lesson_hours_in_basic_education_2012.pdf

³⁰³ <https://www.regjeringen.no/contentassets/b3b9e92cce6742c39581b661a019e504/education-act-norway-with-amendments-entered-2014-2.pdf>

байна. Норвегийн суурь боловсрол нь сурагчдад өөрийгөө илэрхийлэх чадвар, хэл яриа, унших, бичих, ур чадварт суралцах чадварыг суулгах ба хэл, соёл, ёс заншлыг таниулах, хадгалан өвлүүлэх, бусад соёл, ёс заншлыг хүндэтгэх, нийгэмд идэвхтэй оролцох, насан туршийн мэдлэг олгоход чиглэсэн байна.

Бие махбодын болон сэтгэцийн эмгэгтэй хүмүүс, түүнчлэн ямар нэгэн нөхцөл байдлаас шалтгаалан тогтмол сургалттай сургуульд суралцах боломжгүй хүмүүст тусгай боловсрол олгодог.

Стортинг (Норвегийн Парламент) болон Засгийн газар нь боловсролын салбарын төсвийн хөрөнгийн хуваарилалтыг төлөвлөх, хуваарилах үүрэгтэй. Боловсрол, судалгааны яам нь боловсролын тогтолцоог хянах, төрийн боловсролын бодлогын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллага юм.

Норвег нь ерөнхий стандартад суурилсан сургуулийн нэг тогтолцоотой. Засгийн газрын тогтоосон сургалтын стандартыг хянахын тулд улсын сургалтын хөтөлбөрийг боловсруулан, мөрддөг байна. Заавал эзэмших боловсролын хөтөлбөрийн дагуу арван жилийн боловсрол эзэмших бөгөөд үүнд бага, бүрэн бус дунд, бүрэн дунд сургуулиуд багтана. Боловсролын байгууллагуудын үүрэг нь бүхий л хот, бүс нутагт хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд тохирох боловсролоор хангах явдал байна. Орон нутгийн засаг захиргаа нь бага болон дунд сургуулиудын үйл ажиллагааг хариуцдаг бол бүрэн дунд сургуулийн удирдлага, зохион байгуулалтыг бүс нутгийн түвшинд хариуцна.

Норвегид ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгох ба үүнд бүрэн дунд боловсрол орно. Бие даасан хувийн сургуулиуд нь нэмэлт боловсрол олгодог. Бага, дунд боловсролын захиргаа нь боловсролын стандартыг хангасан тохиолдолд бие даасан сургууль байгуулж болоно. Бие даасан сургуулиудын сургалтын хөтөлбөрүүд нь тогтоосон шаардлагыг хангасан байх ба тодорхой шаардлагуудыг хангасан тохиолдолд төрөөс санхүүжилт олгоно.

Норвегид 6-16 насны хүүхдэд 10 жилийн заавал эзэмших боловсрол олгоно. Сургуулийн боловсрол нь 3 шатлалтай байна. Үүнд: бага сургууль (Барнекол), бүрэн бус дунд сургууль (Уустралски), бүрэн дунд сургууль (Видегатеенде сколол) гэсэн 3 шатлалтай.

Бага сургуульд ихэвчлэн 1-ээс 4-р анги, дунд сургуульд 5-аас 7-р анги, ахлах сургуульд 8-аас 10-р анги хүртэл суралцдаг байна. Бага сургуульд заавал судлах хичээлд математик, эх хэл, англи хэлнээс гадна, уран зураг, дуу хөгжим мөн христийн шашин, ёс суртахууны боловсрол, хөдөлмөр болон сонгон нэг нэмэлт хичээл байна. Заавал судлах хичээлүүдээс гадна сурагчид ихэвчлэн (90%) хоёр дахь гадаад хэл сурдаг байна. Сургуулийн эхний өдрөөс эхлэн сурагчдад хүн бүр хувийн зан чанар нь бусадтай харилцсанаар хөгждөг гэдгийг зааж сургаж эхэлдэг байна. Иймд сургалт нь сурагчдын гаргаж буй шийдвэр, тэдгээрийн үр дагаврыг хамтдаа үнэлэхэд суралцах байдлаар зохион байгуулагддаг. Багш нар сурагч бүртэй долоо хоногийн туршид гүйцэтгэх гэрийн болон сургуулийн ажлын төлөвлөгөөг гаргадаг. Багш нар өдөр бүрийн эцэст тусгай тэмдэглэлийн дэвтэрт хүүхдүүдийн амжилтыг тэмдэглэж, шаардлагатай бол эцэг эхчүүдэд ажиглалтаа бичдэг. Норвегийн сургуулийн 1-ээс 7-р ангид дүн тавьдаггүй. Гэхдээ: "багаар ажиллах," "хэлэлцүүлэг," "шийдвэр гаргах" зэргийг дүгнэдэг байна. Сурагчдад 8-р ангиас эхлэн дүн тавих ба шинэ хичээлүүд нэмэгддэг байна. Үүнд: эдийн засаг, экологи, нягтлан бодох бүртгэл ба мэргэжлийн чиг баримжаа олгох хичээлүүд байна.

6 настай 1 дүгээр ангийн бага сургуулийн (Barneskole) сурагчдын хичээл нь хүүхдийг хөгжүүлэх тоглоомын хэлбэрээр явагддаг бөгөөд унших, бичих, тоо бодох чадвартай болж англи хэл сурч эхэлдэг. Хоёрдугаар ангийн хөтөлбөр нь математик, түүх, газарзүй, байгалийн шинжлэх ухааны суурь хичээлүүд орж эхэлдэг байна. Тавдугаар ангиас нийгмийн ухааны хичээлүүд үзэж эхэлдэг байна. Дунд сургуульд сурагчид дээрх хичээлүүдэд гүнзгийрүүлэн судлах бөгөөд 8-р ангиас эхлэн сурагчид өөрсдийн сонирхлоор (valgfar) гадаад хэлнээс герман, франц, испани, эсхүл норвег хэлийг гүнзгийрүүлэн суралцах боломжтой. Дунд сургуульд суралцсан дүнг үндэслэн сурагчид өөрсдийн сонгосон ахлах сургуульд суралцах боломжтой.

1997 онд явагдсан боловсролын шинэтгэлээр сургуульд хамрагдах насыг 7-оос 6 нас болгосон байна. Суурь боловсрол буюу 1-ээс 10-р анги нь үнэ төлбөргүй байна. Жилд 38 долоо хоног хичээллэдэг. Бага сургуульд долоо хоногт 20 цагийн хичээл судална. Математик – 4 цаг, норвег хэл – 6 цаг, байгалийн судлал – 1 цаг, англи хэл – 1 цаг, зураг, хөдөлмөр, биеийн тамир, дуу хөгжим тус бүр - 1-2 цаг, шашин судлал- 2 цаг. Шашны хичээл нь Норвегийн сургуулиуд нь 250 жилийн өмнөөс сүм хийдийг даган байгуулагдаж байсантай холбоотой ба өдгөө библи судлах/шашин судлах нь түүх судлахтай адил гэж тооцдог байна. Ахлах сургууль нь 3 жил байх ба төгсөгчдийн дундаж нас 18-19 нас байна. Сургалтын сүүлийн жил (VG3) сурагчид төгсөлтийн шалгалт өгнө. Ахлах сургууль тус бүр хоёр салбартай байх ба энэ нь академийн сургалт, мэргэжил олгох сургууль байна. Мэргэжил олгох сургуульд хоёр жил суралцсаны дараа сурагчид холбогдох газар, албан байгууллагад цалинтай дадлага (2 жил) хийх бөгөөд, дадлагын хугацаа дууссаны дараа боловсролын гэрчилгээ, мэргэжлийн диплом олгодог.

Ахлах сургуулийн эхний жилд заавал үзэх хичээлд 30 цаг зарцуулдаг. Үүнээс хойш заавал үзэх хичээлийн цаг буурах бөгөөд 2 дахь жилд – 18 цаг, сонгон судлах хичээл – 12 цаг, 3 дахь жилд - 14 цаг, сонгох судлах хичээл – 16 цаг байна. Норвегийн ахлах сургуулиудад шалгалтыг түүвэрлэн явуулах бөгөөд ахлах сургуулийн эхний жилд сурагчдын 10 хувь, хоёр дахь жилд – 25 хувь, гурав дахь жилд сурагчдын 50 хувийг тус тус шалгалтад хамруулдаг байна. Сурагчдад шалгалт авахаас 2 өдрийн өмнө хэн, ямар хичээлээр шалгалт өгөхийг мэдэгддэг байна. Эдгээр сурагчдыг Норвегийн Шалгалтын нарийн бичгийн газраас сурагчдын талаарх мэдээлэл, тэдний сурлагын амжилтын талаарх мэдээллийг авалгүй сонгодог байна. Суралцагчдын шалгалт өгөх хичээлүүд тогтмол байх ба үүнд: мэдээлэл зүй, эдийн засаг, математик (амаар болон бичгээр) мөн англи хэл ордог байна. Дээрх жагсаалтаас 1-2 хичээлээр шалгалт авах бөгөөд төгсөлтийн шалгалтад дээрхээс гадна норвег хэл болон 1 хичээл нэмэлтээр оруулдаг байна.

Ерөнхий боловсролын сургуулиа төгссөний дараа сурагчид их дээд сургууль, коллежид элсэн суралцах зэрэг сонголтоос гадна 1 жил Ардын сургуульд Folkehogskole (Folk high school) суралцаж болдог байна. Энэ төрлийн сургууль анх 150 жилийн өмнө Дани Улсад үүссэн ба өдгөө Скандинавын орнуудад ойролцоогоор 400 орчим байдгаас Норвегид 82 ардын сургууль байдаг байна. Тэдгээр нь ихэвчлэн хот, суурин газраас зайдуу байрлан, спорт, аялал жуулчлал, гадаад хэл, норвег хэл, соёл, гэрэл зураг, хөгжим, театрын урлаг, нийгмийн шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгүүл зүй зэрэг чиглэлээр дагнадаг байна. Тус сургуулийн диплом нь мэргэжлийн гэрчилгээ бус, харин их, дээд сургуульд элсэх оноонд нэмж тооцож болдог байна.

6.КАНАД

Канадын хувьд холбооны түвшинд боловсролын салбарыг хариуцсан салбар яам байхгүй ба үндэсний боловсролын нэгдсэн систем байдаггүй. Канадын Үндсэн хууль (1867он)-д боловсрол олгохтой холбоотой эрх, үүргийг мужуудад олгосон байна. Канад нь арван муж, гурван нутаг дэвсгэрээс бүрдсэн холбооны улс юм. Хойд Канадыг бүрдүүлдэг гурван нутаг дэвсгэр (Нунавут, Баруун хойд бүс нутаг, Юкон)-т үйлчлэх холбооны хуульд мужийн нутаг дэвсгэр бүр боловсрол олгох үүрэг хариуцлагыг адил тэгш хүлээнэ (comparable responsibility) гэж заасан байна. Канадын ерөнхий боловсролтой холбоотой асуудлыг Канадын боловсролын тухай хууль (Education Act), Канадын боловсролын хадгаламжийн тухай хууль (Canada Education Savings Act), муж тус бүрийн боловсролын хуулиудаар зохицуулдаг.

13 мужид яамд, эсхүл департамент нь бага, дунд боловсролын түвшинд боловсрол олгох, зохион байгуулах, үнэлгээ өгөх үүрэгтэй байна. Муж, нутаг дэвсгэр бүр нь өөрийн түүх, соёл болон хүн амын сургалтын хэрэгцээг хангах суурь боловсролын тогтолцооны хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, сургалтын хөтөлбөр, практикийг бий болгоод байна.

Канад Улсад 2013-2014 оны хичээлийн жилд улсын, бага болон дунд сургуульд 4,706,025 сурагч элссэн байна. Бага боловсролд хамрагдах насны хувьд муж улсуудын хувьд харилцан адилгүй байгаа хэдий ч 5 наснаас бага сургуульд элсэн орж, дунд боловсролыг 18 насанд эзэмшиж, төгсөх нь түгээмэл байна.

Газар нутаг, мужуудын боловсролын асуудал хариуцсан сайд нар нь Канадын боловсролын яамны зөвлөлийг бүрдүүлэх ба (Council of Ministers of Education, Canada) Зөвлөлийн хүрээнд харилцан сонирхож буй асуудлаар хэлэлцэх болон арга хэмжээ авахаар хамтран ажилладаг байна.³⁰⁴

Боловсролын тогтолцоо³⁰⁵

Канадын боловсролын тогтолцоог сургуулийн өмнөх, бага болон дунд боловсрол гэж 3 хувааж үздэг байна. Канад Улсад хүүхдүүд муж, нутаг дэвсгэрээс хамааран 5-6 наснаас эхлэн 16-18 нас хүртэл суралцдаг байна. Хичээлийн жилийн 8-р сарын сүүлчээс эхлэн 6-р сарын сүүлч хүртэл хичээллэнэ. Дунд сургуулийг амжилттай төгссөн сурагчдад бага дунд боловсролын гэрчилгээ олгох ба улсын сургуулиуд нь боловсролыг үнэ төлбөргүй олгоно.

Канадын боловсролын тогтолцоог улсдаа боловсролын үзүүлэлтээр тэргүүлдэг Онтарио мужийн жишээн дээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Сургуулийн өмнөх насны боловсролд:

- Цэцэрлэгийн өмнөх боловсрол (3-5 нас)
- Бага боловсрол 1-8-р анги (5-6 наснаас 13-14 нас)
- Дунд боловсрол 9-12-р анги (14-15 наснаас-18-21 нас)* -Зөвхөн Онтарио мужийн хувьд: Дунд сургуулийн сурагчид сургуулиас чөлөө авч болох ба үүнд хугацааны ямарваа нэгэн хязгаар тогтоогоогүй байна.

Канадын муж, нутаг дэвсгэр бүрийн хувьд сургуульд хамрагдах нас, бага, дунд, ахлах сургуульд суралцаж жил зэргийг ялгаатай тогтоосон байна.

Онтарио мужийн хувьд ойролцоогоор 1,4 сая сурагчид ерөнхий боловсролын сургуульд суралцдагаас бага сургуульд 4000 сурагч сурдаг байна. Бага боловсролын сургалт нь хүүхдийн анхаарлыг төвлөрүүлэх, сурагчдын чадавхыг нээхэд чиглэгдсэн байдаг. Онтарио мужийн 8000 гаруй дунд сургуульд 700,000 гаруй сурагч сурдаг байна.

7. ХБНГУ

Боловсролын тогтолцоо

ХБНГУ нь 16 муж улс-Ландераас бүрдэнэ. Холбооны Засгийн газар болон муж улсуудын эрх үүргийг Үндсэн хуулиар тогтоосон. Холбооны Боловсрол, судалгааны яам нь боловсролын асуудалтай холбоотойгоор зөвхөн ерөнхий удирдамжуудыг батлах ба муж улс бүр өөрсдөө хууль тогтоомжоо батлан мөрдөнө. Иймд муж улс бүрийн боловсролын тогтолцоо нь харилцан адилгүй байна.

ХБНГУ-ын дээд боловсрол нь “хосолмол тогтолцоо” (binary system)-ын үндсэн дээр явагддаг ба энэ нь академик болон техник, мэргэжлийн боловсрол гэж хуваагддаг оршино. Хичээлүүд нь ихэвчлэн герман хэл дээр авагдах ба Болонийн процессийн хүрээнд англи хэл дээрх хөтөлбөрүүд (гол төлөв магистрын зэрэг олгох)-ийн тоо нэмэгдэж байна.³⁰⁶

ХБНГУ нь 6-15 насны (16 нас-Берлин, Бранденбург, Бремен) бүх хүүхдэд заавал эзэмших суурь боловсрол олгоно.

Бага боловсрол (*Primarstufe*)-ыг бага сургууль (*Grundschule*)-д олгох ба 6-10-нас хүртлээ хамрагдана. Германы боловсролын тогтолцоонд зөвхөн бага сургуульд бүх сурагчид нэг төрлийн сургуульд хамрагддаг ба нийтлэг хөтөлбөрийн дагуу ерөнхий хичээл үзнэ. Бага сургуулиа дүүргэсний дараа сурагчид төрөлжсөн дунд сургуулиудад элсэн суралцана. Сурагчдыг авьяас, чадвар сурлагыг үндэслэн холбогдох сургуулиудад хуваарилна. Хуваарилах механизм нь муж мужаар ялгаатай байна. Ихэнх муж улсад эцэг, эхчүүд нь хүүхдээ мэргэжлийн сургалттай дунд сургууль, эсхүл их дээд сургуульд бэлтгэх

³⁰⁴ Канадын боловсролын яамны зөвлөлийн бага, дунд боловсролын цахим хаяг
https://www.cmec.ca/680/Elementary-Secondary_Education.html

³⁰⁵ <http://www.edu.gov.on.ca/eng/secondary.html>

³⁰⁶ <https://www.nuffic.nl/en/publications/find-a-publication/education-system-germany.pdf>

дунд сургуульд оруулахыг өөрсдөө сонгох эрхтэй байдаг бол зарим муж улсад сургуулийн тодорхойлолт нь сургуулийн элсэлтэд ихээхэн нөлөөлдөг бол зарим муж улсад сурагчийн сурлагын голч дүнг үндсэн үзүүлэлт болгон хуваарилдаг байна.

Дунд сургууль нь 10-16 насны сурагч хамрагдах дунд сургууль I (*Sekundarstufe/Sekundarbereich I*) болон 16-19 насны сурагч хамрагдах дунд сургуульд II (*Sekundarstufe/Sekundarbereich II*)-д хуваагдана.

- Дунд сургууль I (*Sekundarstufe I*) нь гимназийн 5-10 анги, Хауптшүл (*Hauptschule, 9-р анги*) болон Реалсчүл (*Realschule, 10-р анги*) зэргийг хамарна.
- Дунд сургууль II (*Sekundarstufe II*) нь гимназийн хоёр дахь хэсэг дунд сургууль (*Oberstufe*)-ийн 11-13-р анги, тусгай ахлах сургууль, мэргэжлийн сургалт, ажил, хичээл хосолсон дадлага-сургалт зэргийг хамарна.

Сурагчид нь хамгийн багадаа нэг гадаад хэлийг доод тал нь 5 жил сурах ба гимназид гадаад хэл нь заавал сурах хичээлийн тоонд багтдаг.

Үндэсний өв соёлыг сургалтын хөтөлбөрт тусгасан байдал

Германы бага, дунд сургуулиудын сургалтын хөтөлбөрөөс үзэхэд үндэсний өв, соёлыг хэд хэдэн хичээлийн хүрээнд судалж байна. Үүнд: газар зүй, улс төрийн шинжлэх ухаан, түүх, эх хэл, гадаад хэл, дуу хөгжим, шашин судлал зэрэг байна.

8.ЭСТОНИ

Эстони Улсад Парламент, Засгийн газар болон Боловсрол, шинжлэх ухааны яам нь боловсролын салбартай холбоотой бодлого боловсруулж, эрх үүргийг хэрэгжүүлнэ. Тус улс нь ХБНГУ-тай адил дээд боловсролын “хосолмол тогтолцоо”-той, академик судалгаанд болон мэргэжлийн сургалтад чиглэсэн гэж хуваагдана. Албан ёсны хэл эстони ба үндэсний цөөнх болох орос сурагчдад зориулсан эстони, орос хоёр хэл дээр явагдах сургалтын хөтөлбөртэй сургуулиудтай.³⁰⁷

Эстоний Суурь сургууль болон бүрэн дунд сургуулийн тухай хууль (*Basic Schools and Upper Secondary Schools Act*)-д заасны дагуу суурь боловсрол нь заавал эзэмших боловсролын доод хэмжээг заана. 10 дугаар сарын 1-ний байдлаар 7 нас хүрсэн хүүхэд бүр сургуульд элсэн суралцах ба суурь боловсрол эзэмшиж дуусах нас 17 байна.

Орон нутгийн, эсхүл хотын засаг захиргаа нь өөрийн нутаг дэвсгэр дээр амьдарч буй хүүхэд бүрийг суурь боловсролоор хангах үүрэг хүлээнэ. Сургуульд хүүхдийг хуваарилахад дараахыг үндсэн шалгуур болгоно. Үүнд: сургуулийн байршил (хүүхдийн гэрт хамгийн ойр байрлах сургууль), хүүхдийн ах, эгч нь явдаг сургууль болон эцэг, эхийн сонголт зэрэг байна.

Суурь боловсролыг эцэг, эхийн хүсэлтээр, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар гэрээр олгож болно. Зайны сургалтыг 17 нас хүрсэн, эсхүл онцгой тохиолдолд 17-с доош насны сурагчдад зөвлөх комиссын саналыг үндэслэн олгоно. Бага сургуульд хамрагдахаас өмнө хүүхдийн сургуульд элсэхэд бэлэн байгаа эсэхийг сургуулийн өмнөх боловсролын байгууллага (СӨБ-д хамрагддаггүй хүүхдийг хүүхдийн асран хүмүүжүүлэх байгууллага болон Бүс нутгийн зөвлөх төв) үнэлнэ.

Сургуульд хамрагдахаар заасан наснаас бага насны хүүхдийг эцэг, эхийн хүсэлт болон сургуульд бэлэн эсэхийг үнэлэх эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийг үндэслэн сургуульд хамруулж болно.

Сургууль бүр өөрийн харьяанд байгаа хүүхэд бүрийг хүлээн авах үүрэгтэй. Эцэг, эх нь хүүхдээ орон тоо байгаа тохиолдолд харьяаны өөр сургуульд элсүүлж болно. Хүүхдүүд нь өөрсдийн харьяа сургуульд элсэлтийн шалгалтгүй орох бол зарим тусгай/гүнзгийрүүлсэн сургалттай, элсэлтийг улсын хэмжээнд зохион явуулдаг сургууль нь хүүхдийн авьяас, чадварыг тогтоох элсэлтийн шалгалт авч болно. Хувийн сургуулиуд нь элсэлтийн нэмэлт шалгуур тогтоож болдог байна.

³⁰⁷ <https://www.nuffic.nl/en/publications/find-a-publication/education-system-estonia.pdf>

Эстони нь Финландын адилаар сурагчдыг сургуульд тэгш хамруулах, ижил боломж олгох, эрүүл, аюулгүй, тав тухтай орчинг бүрдүүлэх онцгой анхаарч, илчлэг өндөртэй өдрийн хоол, сурах бичиг зэргийг үнэ төлбөргүй олгодог. 2007 онд батлагдан удирдамжаар сургагчдыг сургуулиа хаяхаас нь урьдчилан сэргийлэх, тусламж, туслалцаа шаардлагатай сурагчдад, боловсролын, сэтгэл зүйн зөвлөөгөө өгөх, хэл ярианы гажиг засалт зэрэг нэмэлт мэргэжлийн туслалцаа үзүүлэхээр тогтоосон байна.

Суурь боловсрол нь 3 шатлалтай байна. Үүнд: 1-р шат 1-3-р анги: 2-р шат 4-6-р анги: 3-р шат 7-9-р анги байна. Эстоний Засгийн газраас 2011 онд баталсан Суурь сургуулийн үндэсний хөтөлбөрт³⁰⁸ суурь боловсролын хүрээнд дараах хичээлийг судална гэж заасан байна. Үүнд:

Үндсэн хичээл/заавал судлах хичээл:

1. эх хэл ба утга зохиол (орос хэл дээр явагддаг хөтөлбөртэй сургуулийн хувьд – орос хэл, утга зохиол);
2. гадаад хэл: гадаад хэл 1, гадаад хэл 2, эстони хэл-(орос сургуульд);
3. математик;
4. байгалийн шинжлэх ухаан: шинжлэх ухаан, биологи, газар зүй, физик, хими;
5. нийгмийн ухааны хичээл: хувийн, нийгмийн болон эрүүл мэндийн боловсрол (PSHE), түүх, иргэний боловсрол;
6. урлагийн хичээл: дуу хөгжим, урлаг;
7. технологи: (employment studies), хөдөлмөр, гар урлал, техник технологи;
8. биеийн тамир.

Сонгон судлах:

1. шашин судлал (*тус хичээлийг гагцхүү Үндэсний сургалтын хөтөлбөрт заасан хичээлийн агуулгын хүрээнд судална*);
2. информатикийн хичээл;
3. мэргэжил сонгох;
4. бизнес судлал (entrepreneurial studies). */тус хичээлийн хүрээнд сурагчид хэрэглэгч, ажилтан, аж ахуй эрхлэгчдийн эрх, үүрэг, аж ахуй эрхэлдэг, ажилтан, удирдах ажилтны үүрэг, хариуцлага, аж ахуй, компаниудын нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар ойлголт авч, олон төрлийн мэдээллийн эх сурвалжаас мэдээ авч, шүүмжлэлтэй сэтгэх, зорилго тавьж түүнийг хэрэгжүүлэх, багаар ажиллах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх/*

Гадаад хэлний сургалт

Эстоний хэлний тухай хуульд зааснаар гадаад хэл гэж эстони болон эстони дохионы хэлнээс бусад бүх хэлийг хэлнэ. Сургуулиудад ихэвчлэн 2 гадаад хэл заах ба англи, франц, герман, орос хэлийг ихэвчлэн 1 дүгээр хэл болгон судлах ба сурагчид англи хэлийг сонгох нь түгээмэл. Суурь сургуулийн үндэсний хөтөлбөрт сурагчдын сонирхол, сургуулийн боломж бололцоог харгалзан аль ч гадаад хэлийг 2 дугаар гадаад хэл болгон зааж болно.

Бүрэн дунд сургуулийг төгсөхөд сурагчид нь англи хэлний шалгалт болон/эсхүл герман, франц, орос хэлний шалгалт заавал өгнө. Сургалтын 1-р шат (1-3-р анги)-нд нэгдүгээр гадаад хэлийг долоо хоногт 3 цаг судална.

Үндэсний өв, соёлыг сургалтын хөтөлбөрт тусгасан байдал

Суурь сургуулийн үндэсний хөтөлбөр (*National curriculum for basic schools*)-т соёлын өвтэй холбоотой асуудлыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

2 дугаар зүйлд суурь боловсролын үндсэн үнэт зүйлсийг тодорхойлсон ба 2.3-т Сургалтын хөтөлбөрт чухал гэж тооцсон үнэт зүйлс нь Эстоний Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенц болон Европын холбооны

³⁰⁸ National curriculum for basic schools, 2011

https://www.hm.ee/sites/default/files/est_basic_school_nat_cur_2014_general_part_1.pdf

суурь баримт бичгүүдэд заасан ёс зүйн зарчмуудаас үүдэлтэй байна. Хувь хүний нийтлэг үнэт зүйлс (үнэнч, энэрэнгүй байх, шударга ёс, өөрийгөө болон бусдыг хүндэтгэх) болон нийгмийн үнэт зүйлс (эрх чөлөө, ардчилал, эх хэл, соёлыг хүндэтгэх, эх оронч үзэл, соёлын ялгаатай байдлыг хүндэтгэх, байгаль орчны тогтвортой байдал, хууль дээдлэх ёс, үүрэг хариуцлага болон жендерийн эрх тэгш байдал) нь боловсролын үндсэн үнэт зүйлс байна. 2.4-т Эстоний соёлын уламжлал, Европын нийтлэг үнэт зүйлс, дэлхийн соёл, шинжлэх ухааны ололт амжилтыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр өсвөр үе, хүүхэд залуучуудын нийгэмших үйл ажиллагаа явагдана. Чанартай суурь боловсрол эзэмшсэн хүмүүс нийгэмд дасан зохицох чадвартай байж, Эстоний нийгэм, соёл, эдийн засаг, экологийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах болно гэж тус тус заасан байна.

3-р зүйлд суурь сургуулийн зорилтуудыг тодорхойлсон ба 3.7-д Эстоний сургуулиуд нь Эстони үндэстэн, хэл, соёлыг хамгаалж, хөгжүүлэх үүргийг хүлээсэн учир суурь сургуульд эстони хэлийг судлахад онцгой анхаарна гэж заасан.

4-р зүйлд сурагчдад ямар чадамж эзэмшүүлэх талаар заасан ба 4.3.1-д соёл, үнэт зүйлсийг үнэлэх чадамж нь хүмүүс хоорондын харилцаа, үйл ажиллагааг нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээний хүрээнд/үүднээс үнэлэх; бусад хүмүүс, нийгэм, байгаль орчин, өөрийн орны болон бусад улсын соёлын өвтэй холбоотой холбоо, харилцааг мэдэрч, үнэлэх; гоо зүйн мэдрэмжтэй болж, үнэлэх; хүний болон нийгмийн ерөнхий үнэт зүйлсийг үнэлэх, хүн төрөлхтөн, соёл, байгалийн олон янз байдлыг үнэлэх, өөрийн үнэт зүйлийг тодорхойлох зэрэг болно.

11-р зүйлд сургалтын 3 дугаар шатанд (7-9-р анги) эзэмших чадваруудыг тодорхойлсон ба 11.11-д өөрийгөө бүтээлч байдлаар илэрхийлж, урлаг, соёлыг өвийг хүндэтгэх гэж заасан.

14-р зүйлд хичээл хоорондын уялдаа холбоог тодорхойлсон ба 14.4-т соёлын ижилсэл нь сурагчийг соёлын талаарх мэдлэгтэй болгож, хүний үзэл бодол, зан байдалд соёлын үзүүлэх нөлөөг ойлгодог, соёлыг түүхэн өөрчлөлтүүдийг мэддэг, соёлын олон янз байдал, хүний амьдралын хэв маягт соёл, зан заншлын нөлөөг ойлгож, үндэсний соёл, соёлын олон янз байдлыг хүндэтгэж, соёлын тэвчээртэй байж хамтран ажиллахад бэлэн байхад чиглэгдэнэ гэж тодорхойлсон байна.

9. ШИНЭ ЗЕЛАНД

Шинэ Зеланд нь гурван албан ёсны хэлтэй ба эдгээр нь англи, маори болон Шинэ Зеландын дохионы хэл байна. Боловсролтой холбоотой асуудлыг 1989 онд батлагдсан Боловсролын тухай хуулиар зохицуулна. Боловсролын яам нь боловсролын талаар баримтлах бодлого боловсруулах, боловсролын байгууллагуудад олгосон санхүүжилтийг хуваарилах, боловсролтой холбоотой мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, боловсролын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт, шинжилгээ хийх үүрэгтэй байна.

Тус улс нь боловсролын салбартаа ихээхэн анхаарал хандуулан, ах холбогдол өгдөг ба нэг сурагчид ногдох зардлын хэмжээгээр ЭЗХАХБ-ын дунджаас доогуур байгаа ч боловсролын салбарт зарцуулж буй төсвийн зарцуулалтын (13,2%) хэмжээгээр дэлхийд дээгүүр байр эзэлдэг.³⁰⁹

Шинэ Зеланд нь 6-16 насны бүх хүүхдэд заавал эзэмших суурь боловсрол олгох ч ихэнх хүүхдүүд 5 наснаас сургуульд хамрагддаг байна. 5-19 насанд олгох боловсролыг үнэ төлбөргүй олгоно.

Сургуулиуд нь улсын, шашны болон хувийн гэсэн 3 төрөлтэй. Улсын сургуулиуд нь үнэ төлбөргүй байх ба хүүхдүүд харьяаллын дагуу хамгийн ойр байрлах сургуульд хамрагдана. Энэ төрлийн сургууль нь үнэ төлбөргүй байх боловч, сурах бичиг, дүрэмт хувцас, сургуулийн хэрэглэл зэргийг сурагчийн эцэг, эх хариуцна. Шашны сургалттай улсын сургууль (гол төлөв Католик сургууль) нь үнэ төлбөргүй байх, дээрхтэй адил зарим зардлыг сурагчийн эцэг, эх хариуцна. Хувийн сургуулиуд нь шашны боловсрол,

³⁰⁹ <https://data.oecd.org/eduresource/public-spending-on-education.htm>

гүнзгийрүүлсэн сургалт зэргийг олгож болно.

Бага, дунд боловсрол

Бага боловсролыг 5-аас дээш насны хүүхдэд олгож болох ч заавал эзэмших боловсролыг 6-16 насанд олгоно. Сургалтын үндэсний хөтөлбөр 1-10-р ангийг багтаах ба 1-8 анги нь бага боловсрол, 9-10 анги нь бага дунд боловсрол 11-13-р анги нь бүрэн дунд боловсрол байна. 11-13-р анги нь заавал эзэмших боловсролд хамаарахгүй боловч дээд боловсролд эзэмшихэд зайлшгүй шаардлагатай. Гадаад хэлийг 1-р ангиас эхлэн заана. (Common European Framework for Languages, Global Scale Level A1: Basic User; Council of Europe, 2001)

Сургалтын үндэсний хөтөлбөрийн хүрээнд дараах хичээлийг судална:

- Англи хэл;
- Урлаг;
- Эрүүл мэнд ба биеийн тамир;
- Гадаад хэл;
- Математик;
- Шинжлэх ухаан;
- Нийгмийн ухаан;
- Технологи.

Үндэсний өв, соёлыг сургалтын хөтөлбөрт тусгасан байдал

1989 оны Боловсролын тухай хуульд заасны дагуу сургууль бүр төлөөлөн удирдах зөвлөлтэй (Board of Trustees) байна гэж заасан ба тэдгээрийн эрх, үүргийн нарийвчлан тогтоосон байна. Төлөөлөн удирдах зөвлөлийг Боловсролын тухай хууль, Төлөөлөн удирдах зөвлөл сонгох тухай тогтоолд заасан журмын дагуу 3 дээшгүй жилээр сонгоно.

Төлөөлөн удирдах зөвлөл нь сургуулийн дүрмийг (School charter) батлах ба боловсролын шаардлагад нийцүүлэн тухай бүр шинэчлэх үүргийг хүлээнэ. Ингэхдээ сургуулийн дүрэмд Шинэ Зеландын соёлын олон янз байдал ба маори үндэсний хэл, соёлыг тусгахад онцгой анхаарал хандуулна. Дээрхийн хүрээнд сургууль нь сурагчийн эцэг, эх нь хүсэлт гаргасан бол маори хэл дээр сургалт явуулах, маори үндэсний өв, соёлыг таниулах асуудлаар боломжит арга хэмжээ авна.

10.НИДЕРЛАНД

Нидерландын Вант Улсын боловсролын салбарыг Дээд боловсрол, судалгааны тухай хууль, Сурагчдын тэтгэлгийн тухай хуулиар зохицуулж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь боловсролын байгууллагад олгосон санхүүжилтийг хуваарилах, боловсролын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, сургуулийн элсэлтийн журам, ерөнхий тогтолцоо, зорилго зэргийг тогтооно. Тус улсын боловсролын шатлал бүрд (бага, дунд, дээд) зохицуулалтыг бууруулах хандлага ажиглагддаг ба сургуулийн байгууллагууд нь Засгийн газраас баталсан бодлогыг хэрэгжүүлэх үүргийг хүлээх нь нийтлэг байна.

Голландын боловсролын тогтолцоо нь 8 жилийн бага сургууль, 4-6 жилийн дунд сургууль (төрлөөсөө хамааран), 2-6 жилийн их, дээд сургуулиас (сургуулийн төрөл, чиглэлээс хамааран) бүрдэж байна. Боловсролын шатлал бүрд улсын болон хувийн сургуулиуд байх ба хувийн сургуулиудын дийлэнхийг шашны, эсхүл үзэл суртлын зарчим дээр суурилсан сургуулиуд бүрдүүлдэг байна. Заавал олгох боловсролд 5-16 насны хүүхдийг хамруулна.

Бага сургууль

Бага боловсролыг 4-12 насанд олгох ба сургууль хүүхдийг 5 наснаас хамруулна. Бага боловсрол нь 8 жил байх ба бага сургууль, эсхүл тусгай боловсролын сургуулиуд олгоно. Сурагчдын сонирхол болон сурлагын амжилтыг харгалзан дунд сургуульд элсэн суралцуулна. Бага сургуулийн төгсөх буюу 8 дугаар ангид сурагчдын сургуулийн тодорхойлолт болон түвшин тогтоох шалгалтын дүн, сурагчдын хүсэл, сонирхлыг үндэслэн цаашид үргэлжлүүлэн суралцах дунд сургуулийн сонголт хийгдэнэ. Сурагчид нь

ерөнхий дунд сургууль (HAVO) болон мэргэжил олгох дунд сургууль (VMBO)-ийн нэгийг сонгох юм.

Дунд сургууль

Ерөнхий дунд боловсрол нь 5-6 жил байх ба 16 нас хүртэлх хүүхэд бүр заавал эзэмшинэ. Сурагчид 2 төрлийн сургуулиас сонголтоо хийх ба тус бүр 2-3 жилийн чиглүүлэх сургалт явагдана. Ерөнхий дунд боловсрол сургуулиуд нь дотроо 2 төрөлтэй байх ба эдгээр нь 6 жилийн их, дээд сургуулийн өмнөх сургууль “VWO” (үүнд: гимнази, лицей, atheneum орно) болон 5 жилийн сургалт бүхий ерөнхий дунд сургууль (HAVO) байна. Дунд сургуулийн төгсгөлд 6-7 хичээлээр улсын шалгалт өгөх ба VWO, эсхүл HAVO боловсролын гэрчилгээ олгоно. Дээрх сургуулиудыг дүүргэснээр их, дээд сургуульд суралцах эрхтэй болох ба соёл ба нийгэм, эдийн засаг ба нийгэм, шинжлэх ухаан ба эрүүл мэнд, шинжлэх ухаан ба технологи гэх дөрвөн кластерын нэгээр дагнан суралцаж, тухайн кластерт тавигдаж буй шаардлагыг хангасан байна.

Мэргэжил олгох дунд сургууль VMBO нь мэргэжил олгоход чиглэгдэх ба 4 жил байна. Ерөнхий дунд сургуультай адил 2 жил бэлтгэл буюу чиглүүлэх сургалт явагддаг. 2 дахь жилээсээ сурагчид цаашид суралцах сектор, чиглэлээ сонгодог байна. VMBO нь 4 сектортой байх ба эдгээр нь технологи, эрүүл мэнд ба хувийн халамж, асрамж, эдийн засаг, хөдөө аж ахуй зэрэг байна. Сектор түр бүрт сурагчид чиглэлээ сонгох ба тэдгээр нь дотроо үндсэн мэргэжлийн, ахисан түвшний мэргэжлийн, хосолмол ба онолын гэж хуваагдана. Онолын чиглэл нь ерөнхий дунд сургууль болон мэргэжил олгох ахлах дунд MBO дахь мэргэжлийн сургалт, менежментийн сургалтад элсэх эрхийг олгох бол бусад чиглэлүүд нь ерөнхий дунд сургуульд элсэх эрхийг олгохгүй ч мэргэжил олгох ахлах дунд сургууль MBO-д элсэхэд бэлтгэл болох юм.

Мэргэжил олгох ахлах дунд сургууль (MBO) сурагчдад мэргэжил олгох VMBO сургуулийн үргэлжлэл байна. Сургалтын хугацаа нь сонгосон чиглэлээс хамааран ялгаатай байна. Мэргэжил олгох ахлах дунд сургууль нь бүсийн сургалтын төв (БСТ), хөдөө аж ахуйн сургалтын төв (ХХАСТ) болон мэргэжил олгох сургуулийн үргэлжлэл байна. Мэргэжил олгох ахлах дунд сургуулийн сурагчид нь 2 чиглэлээс сонголт хийх боломжтой ба нэг нь сургуульд суурилсан боловсрол (сургалтын 20%-иас доошгүй, 60%-иас дээшгүй хувьд нь дадлага хийх), эсхүл ажилд суурилсан чиглэл (сургалтын 60%-аас доошгүй хувьд нь дадлага хийх) байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <http://data.uis.unesco.org/index.aspx?queryid=218>
- <https://www.moe.gov.sg/education/education-system>
- <https://www.moe.gov.sg/education/education-system/compulsory-education>
- <http://www.singaporelaw.sg/sglaw/laws-of-singapore/overview/chapter-1>
- Compulsory Education Act, Singapore
- <https://sso.agc.gov.sg/Act/CEA2000?ViewType=Advance&Phrase=The+Compulsory+Education+Act&WiAl=1>
- Fundamental principles of the national education systems, 2015
- <https://www.cesifo-group.de/ifoHome/facts/DICE/Education-and-Innovation/Education/Organisation/fundamental-principles-education-systems/fileBinary/fundamental-principles-education-systems.pdf>
- <https://webgate.ec.europa.eu/fpfis/mwikis/eurydice/index.php/Netherlands:Overview>
- https://webgate.ec.europa.eu/fpfis/mwikis/eurydice/index.php/Netherlands:Secondary_and_Post-Secondary_Non-Tertiary_Education
- http://www.oph.fi/download/146428_Finnish_Education_in_a_Nutshell.pdf
- <https://wenr.wes.org/2013/06/wenr-june-2013-an-overview-of-education-in-south-korea>
- http://elaw.klri.re.kr/eng_mobile/partList.do?seq=16
- The school curriculum of the Republic of Korea, 2008
- <http://ncic.go.kr/english.kri.org.inventoryList.do>
- http://gangwonepik.weebly.com/uploads/1/3/8/5/13851570/national_school_curriculum-english2008.pdf
- National Identity in Korean Curriculum, Hyojeong Kim University of Alberta, CANADIAN SOCIAL STUDIES VOLUME 38 NUMBER 3, SPRING 2004 www.quasar.ualberta.ca/css
- <https://files.eric.ed.gov/fulltext/EJ1073922.pdf>
- Elementary Moral Education and Social Studies in South Korea, Hang-In Kim, Ho-Bhum Cheong, John D. Hoge, Ronald L. VanSickle, and Young-Seok Kim
- <http://www.socialstudies.org/sites/default/files/publications/yl/1304/130402.html>
- https://www.cmec.ca/680/Elementary-Secondary_Education.html
- <https://www.canada.ca/en/immigration-refugees-citizenship/services/new-immigrants/new-life-canada/enrol-school/elementary-secondary.html>
- <http://www.edu.gov.on.ca/eng/secondary.html>
- https://news.ontario.ca/opo/en/2017/09/updated-curriculum-new-report-cards-coming-to-ontario-schools.html?_ga=2.137675314.380025761.1517482053-1749965847.1516785238
- <https://www.pc.gc.ca/en/culture/clmhc-hsmbc/ppf-csp>
- <https://www.canada.ca/en/canadian-heritage.html>
- https://www.udir.no/Upload/Brosjyrer/5/Education_in_Norway.pdf?epslanguage=no
- <https://www.udir.no/>
- <https://web.archive.org/web/20071111185114/http://www.norway.org.uk/education/education/primary/primary.htm>
- <https://www.regjeringen.no/en/topics/education/school/artikler/regelverk-for-skolen/id2353805/>
- <https://www.justlanded.com/english/Norway/Norway-Guide/Education/Schools-in-Norway>
- <https://www.moe.gov.sg/education/landscape/>
- <https://www.schoolbag.sg/images/default-source/infographic/the-singapore-education-journey.jpg>
- <https://www.hm.ee/en/activities/pre-school-basic-and-secondary-education/basic-education>
- <https://www.hm.ee/en/national-curricula-2014>
- https://www.hm.ee/sites/default/files/est_basic_school_nat_cur_2014_general_part_1.pdf
- http://web-local.rudn.ru/web-local/uem/iop_pdf/247-Tkach.pdf